



**Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн
хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр
дүн, үр ашиг**

**ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДАЛ
ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНД
СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ
БАЙНА**



Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын
газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор
М.Давааням

Аудитын менежер:
Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор:
Б.Саруул

Аудитор:
Б.Анхбаатар
Б.Лхагвацэрэн
Б.Хишигтогтох
Б.Хаш-Эрдэнэ
Д.Эрдэнэцогт
М.Туул

YAГ-ын Гүйцэтгэлийн
аудитын болон аймаг,
нийслэл дэх Төрийн аудитын
газрын аудиторуд оролцов.

2017 оны 6 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, лавлах зүйл
байвал 261675, 261456,
263755 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

**Уг тайланг YAГ-ын Веб
сайтаас үзнэ үү.**
www.audit.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160

Монгол Улс

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	5

Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөхдөө хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна

▪ Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслүүд хэрэгжээгүй байна	8
▪ Төлөвлөлтийн горимын алдааг арилгах, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад баримтлах нэгдсэн аргачлал шаардлагатай байна	8
▪ Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийн 75 хувийг дэд бүтцийн салбарт хуваарилжээ	11
▪ Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасаар байна	11
▪ Худалдан авах ажиллагааны ил тод байдал бүрэн хангагдахгүй байна	14
▪ ТЭЗ-дын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд өгсөн үнэлгээ өмнөх оноос 2.7 пунктээр буурчээ	15
▪ Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг бүрэн мөрдөхгүй байна	16

Бүлэг 2. Оролцогч талуудын хариуцлага сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

▪ Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна	19
▪ Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ	20
▪ Захиалагч эрх мэдлээ хэтрүүлснээс төсвийн хөрөнгийг илүү үр ашигтай төсөл, арга хэмжээнд зарцуулах боломжийг алдагдуулж байна	21
▪ Захиалагчийн хяналтын зардлын ашиглалт, зарцуулалт хангалтгүй байна	22
▪ Улсын комиссын үйл ажиллагаа шаардлагын түвшинд хүрэхгүй байна	22
▪ Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна	23
▪ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөө хангалтгүй байна	25
▪ Сангийн яам 2016 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан байна	27

Бүлэг 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй, хэрэгжилтэд тавих хяналт сул байна

▪ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оны гүйцэтгэлээс 3.4 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна	29
▪ Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна	30
▪ Худалдан авалтад харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг түлхүү хэрэглэж ирснээр төсвийн хэмнэлт бага гарч байна	30
▪ Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 13.6 хувийг улсын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихэд зарцуулсан байна	32
▪ Захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас өмнөх зөрчлүүд давтагдан гарч байна	34

Холбогдох байгууллагын санал

Дүгнэлт:

Зөвлөмж:

ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хугацаандаа хэрэгжээгүй ТАХ-ний судалгаа	42
Хавсралт 2. Улсын төсвийн 2016 оны хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй ТАХ-ний судалгаа	45
Хавсралт 3. Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэн боловч хугацаандаа хэрэгжээгүй ТАХ-ний судалгаа	46
Хавсралт 4. Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжих санхүүжилт олгогдоогүй ТАХ-ний судалгаа	47
Хавсралт 5. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжилт нь эхэлсэн боловч 2016 онд хөрөнгө төлөвлөгдөөгүй орхигдсон ТАХ-ний судалгаа	48
Хавсралт 6. Эрчим хүчний салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан боловч ашиглалтгүй, хэрэгжилт дутуу ТАХ-ний судалгаа	51
Хавсралт 7. Шилжих хөрөнгө оруулалтын 2016 онд төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	52

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам засвар, арчлалт
АХБ	Азийн Хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОНХАЖС	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд (хуучин нэрээр)
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХАҮН	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХС	Батлан хамгаалахын сайд
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТАХ	Төсөл, арга хэмжээ (төсөл)
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УЕП	Улсын ерөнхий прокурор
УИХ	Улсын Их Хурал
УИХД	Улсын Их Хурлын дарга
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (хуучин нэрээр)
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМСС	Эрүүл мэнд, спортын сайд (хуучин нэрээр)
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудит хийсэн үндэслэл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5¹-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ. Улсын болон орон нутгийн 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд: - Улсын төсөв болон төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Монгол Улсын Хөгжлийн банкнаас (цаашид Хөгжлийн банк гэх) 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжсэн эсэх, - Улсын төсөв болон төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх, - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө болон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэр, векселиэр төлбөр гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагчид, Сангийн яам (Санхүүгийн бодлогын газар, Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Өрийн удирдлагын хэлтэс), холбогдох байгууллага болон аймаг, нийслэлийн хяналтын чиг үүрэг, гүйцэтгэлийг хариуцагч эрх бүхий байгууллагууд, ажил гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгжийн хүрээнд шалгалаа. Улсын төсвөөс 2016 онд санхүүжүүлсэн концессын 3 гэрээний эргэн төлөлтийг ҮАГ-аас 2017 оны сүүлийн хагаст хийх “Концессын тухай хуулиар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийх аудитын дүнд нэгтгэхээр хойшлуулав.
Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын холбогдох нэгжийн албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитад ашигласан шалгуур	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: - Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн 2, 3, 4 дүгээр хавсралт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, - Төсвийн тухай хуулийн 6, 10, 11, 12, 13, 27, 28, 29 дүгээр зүйл, - Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйл, - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, - Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйл - Иргэний хуулийн 243-261, 343-358 дугаар зүйл, - Концессын тухай хууль, - Авто замын тухай хуулийн 4, 5, 13, 14, 15, 16, 18, 19, 20 дугаар зүйл, - Эрчим хүчний тухай хуулийн 9, 20, 25 дугаар зүйл, - Сангийн сайдын 2012 оны 290, 264 дүгээр тушаалаар батлагдсан журам, - Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

¹ Улсын төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр дүнд аудит хийх

Ерөнхий мэдээлэл

Улсын хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10²-д заасны дагуу Сангийн яам, Хөгжлийн банк, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар³ болон Үндэсний хөгжлийн газар, ТЕЗ нар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах журмыг 2010 оны 123 дугаар тогтоолоор баталж, Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 28 дугаар зүйлийн 28.8⁴-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 223 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг баталжээ.

Жил бүрийн улсын төсвийн төлөвлөлт, төсвийн тодотголд дээрх хөтөлбөрт заасан төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардлын санхүүгийн эх үүсвэрийг тусгаж байх, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг тооцоолох шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах замаар хөгжлийн төлөвлөлтөд нийцүүлэх, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлэх төслүүдэд төсвөөс гаргах нийт хөрөнгийн хязгаарыг олон улсын жишгийг баримтлан оновчтой тогтоохыг Сангийн сайдад даалгасан байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичиг байна” гэж заажээ.

Гэтэл дээрх хөтөлбөрийн хэрэгжих хугацааны туршид төсөв, санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан тодотгол хийгээгүй, төсвийн хөрөнгийн дутагдлаас шалтгаалан хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжээгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Үндэсний хөгжлийн газраас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, Төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар 2016 онд тодорхой арга хэмжээг зохион байгуулаагүй бөгөөд тус газрын даргын 2017 оны А/40 дүгээр тушаалаар “Хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах ажлын хэсэг байгуулагдан ТЕЗ-даас санал авч, хөтөлбөрийн төслийг 2017 оны 5 дугаар сард Засгийн газарт өргөн барьсан байна.

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлэх зорилт дэвшүүлсэн ч ОУВС-тай байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн дагуу ирэх жилүүдэд “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдах шинэ хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон үйлдвэрлэл, дэд бүтцийн гэх мэт арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэх боломж хомс байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөлөлд хөрөнгийн зардлын хэмжээг 1,930.5 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 7.0 хувь байхаар тогтоосныг 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хөрөнгийн зардлын хэмжээг 2,350.0 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 9.7 хувь байхаар буюу 2.7 хувиар нэмэгдүүлэн өөрчилсөн байна.


² улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон концессын гэрээ, Засгийн газрын өрийн баталгаа, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна

³ УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинээр байгуулж, ЗГХА ХААГ, Сангийн яамны бүтцийн нэгжийн Төрийн өмчийн удирдлага, бүртгэл, тооллого, хяналтын газрын чиг үүргийг шинээр байгуулагдсан агентлагт шилжүүлсэн.

⁴ Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.

Энэ нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хамгийн өндөр үе буюу 2011 оны 17.3 хувийн өсөлттэй дүйцэж байна. Эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 2016 онд 1 хувьтай гарсан байна.

Дүрслэл 1. Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь (тэрбум төгрөг, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам

Төсвийн хөрөнгө оруулалтыг салбараар ангилбал, 2016 онд зарим салбарт оруулсан хөрөнгө оруулалтад ихээхэн өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, сүүлийн 5 жилийн дунджаас хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөрөнгө оруулалт 3.2 дахин, зам, эрчим хүч, барилга хот байгуулалтын салбарын хөрөнгө оруулалт 2.1 дахин, батлан хамгаалах, хууль, хүчний байгууллагын салбарын хөрөнгө оруулалт 1.4 дахин тус тус нэмэгдсэн бол байгаль орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгийн хэмжээ буурсан байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээр харуулав)

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын ангилал (салбараар, тэрбум төгрөг, хувь)

Ангилал	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	5 жил дундаж	2016* он	2016/ 5 жил дундаж (хувь)
Дэд бүтцийн салбар	396.6	566.6	422.3	398.5	449.9	446.8	925.1	107.1
Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбар	125.6	154.3	98.5	191.4	91.7	132.3	152.3	15.1
Эрүүл мэндийн салбар	79.0	83.6	30.6	106.9	40.9	68.2	55.8	(18.2)
Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын салбар	4.2	16.5	8.3	23.9	7.0	12.0	38.4	220.5
Төрийн төв байгууллагууд	187.3	212.4	170.5	169.5	74.3	162.8	29.6	(81.8)
Батлан хамгаалах, хууль хүчний байгууллагууд	18.0	14.6	13.9	27.8	3.1	15.5	21.7	40.2
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбар	84.3	67.5	39.5	49.2	11.6	50.4	8.6	(82.9)
Хүнд үйлдвэрийн салбар	5.0	4.1	3.8	4.0	2.0	3.8	0.7	(81.5)
Дүн	900.0	1,119.6	787.4	971.2	680.5		1,232.2	

Эх сурвалж: ҮАГ-ын судалгаа

*урьдчилсан гүйцэтгэл

Төсвийн хөрөнгө оруулалтын 2016 оны гүйцэтгэлийг санхүүжилтийн эх үүсвэрээр өмнөх онтой харьцуулахад Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн санхүүжилт буурчээ. (Дэлгэрэнгүйг хүснэгтээр 2-оор харуулав)

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр (тэрбум төгрөг, хувь)

Санхүүжилтийн эх үүсвэр	2015 онд				2016 онд				Өсөлт (+), бууралт (-) 2016/2015
	ТАХ- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт		ТАХ- ний тоо	Санхүү- жих дүн	Санхүүжилт		
			Мөнгөн дүн	Хувь			Мөнгөн дүн	Хувь	
Улсын төсөв	415	358.0	246.8	68.9	293	303.6	246.4	81.2	(0.4)
Засгийн газрын векселийн эргэн төлөлт					411	672.9	659.5	98.0	659.5
Концессын эргэн төлөлт					3	70.7	70.7	100.0	70.7
Хөгжлийн банк	214	452.3	433.7	95.9	109	311.6	252.8	81.1	(180.9)
Орон нутгийн төсөв	1640	359.6	260.6	72.5	2239	301.9	264.1	87.5	3.5
Нийт дүн	2269	1,169.9	941.1	80.4	3055	1,660.7	1,493.5	89.9	552.4

Эх сурвалж: ҮАГ-ын судалгаа

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 8 мянган суудалтай 17 сургуулийн барилга, өргөтгөл, 620 ортой 6 дотуур байр, 2170 ортой 19 цэцэрлэг, 545 ортой 18 хүн эмнэлэг, эмнэлгийн өргөтгөл, 65.3 км 3 чиглэлийн ЦДАШ, 4 дэд станц, 11 чиглэлд 176.6 км авто зам ашиглалтад орсон байна. (Дэлгэрэнгүйг хүснэгтээр 3-аар харуулав)

Хүснэгт 3. Төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламж (хүчин чадлаар)

Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	5 жил дундаж	2016 он	5 жилийн дунджаас өссөн, буурсан
Хатуу хучилттай авто зам	км	335.0	151.0	336.0	435.0	1171.9	485.8	176.6	(309.2)
Төмөр бетон гүүр	у/м	374.0	545.0	320.0	1259.0	586.2	616.8	289.9	(326.9)
ЦДАШ	км	459.0	743.0	636.0	472.0	562.4	574.5	65.3	(509.2)
Хүүхдийн цэцэрлэг	орны тоо	3270	3200	2150	3125	1820	2713	2170	(543)
ЕБС, оюутны хичээлийн байр	суудлын тоо	5880	11558	6248	11183	7280	8430	8008	(422)
Сургуулийн дотуур байр	орны тоо	930	930	1430	1000	1270	1112	620	(492)
Соёлын төв	суудлын тоо	1780	1890	1250	2000	2320	1848	1400	(448)
Хүн эмнэлэг	орны тоо	310	200	270	445	460	337	545	208

Эх сурвалж: ҮАГ-ын судалгаа

Үлдэгдэл санхүүжилт бүхий 343 ТАХ-ний гүйцэтгэлийг векселиэр баталгаажуулсантай холбоотой 2016 онд төсвийн хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилтийн хэмжээ өссөн ч ашиглалтад орсон барилга байгууламжийн тоо 5 жилийн дунджаас буурсан байна.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөхдөө хууль, журмын холбогдох заалтыг мөрдөөгүй байна

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслүүд хэрэгжээгүй байна

1.1 Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Засгийн газрын 2008-2012 үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг үндэслэн боловсруулсан “Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 2016 онд улсын төсвийн эх үүсвэрээр 4,508.9 тэрбум, Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр 2,333.7 тэрбум, хувийн хэвшлийн хөрөнгөөр 5,957.1 тэрбум, гадаадын зээлийн хөрөнгөөр 729.4 тэрбум, тусламжийн хөрөнгөөр 20.3 тэрбум, нийт 13,549.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

1.2 Хөтөлбөрт 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй буюу нийт 1,427.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 342 ТАХ-нд 623.7 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгагдсан нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1⁵-д заасантай нийцэхгүй байна.

1.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаагүй, төсөв санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан тодотгол хийгээгүй, төсвийн хөрөнгийн дутагдлаас шалтгаалан хөтөлбөрт тусгагдсан томоохон арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал,

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Мэдээлэл холбооны өндөр технологийн инновацийн кластер байгуулах, төсөвт өртөг 300.0 тэрбум, санхүүжих дүн 130.0 тэрбум,
- Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул хөөргөх, төсөвт өртөг 600.0 тэрбум, санхүүжих дүн 200.0 тэрбум,
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийн цогцолбор хөгжүүлэх, төсөвт өртөг 600.0 тэрбум, 2016 онд санхүүжих дүн 55.0 тэрбум,
- Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 230 км ЦДАШ, Сайншандын 220 кВ-ын дэд станцыг барих, төсөвт өртөг 64.2 тэрбум, санхүүжих дүн 34.2 тэрбум,

Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр:

- Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын дэд бүтэц, төсөвт өртөг 575.0 тэрбум, 2016 онд санхүүжих дүн 150.0 тэрбум,
- Нүүрс шингэрүүлэх үйлдвэр, төсөвт өртөг 250.0 тэрбум, санхүүжих дүн 20.0 тэрбум,
- Коксын үйлдвэр, төсөвт өртөг 300.0 тэрбум, санхүүжих дүн 85.0 тэрбум,
- Зүүн бүсэд өнгөт металлургийн үйлдвэр барих, төсөвт өртөг 100.0 тэрбум, санхүүжих дүн 20.0 тэрбум,
- Зэс хайлуулах үйлдвэр байгуулах, төсөвт өртөг 375.0 тэрбум, санхүүжих дүн 75.0 тэрбум,
- Үрлэн төмрийн үйлдвэр байгуулах, төсөвт өртөг 600.0 тэрбум, санхүүжих дүн 200.0 тэрбум,
- Сэлэнгэ мөрний ай савд усан цахилгаан станц барих, төсөвт өртөг 107.0 тэрбум, санхүүжих дүн 46.6 тэрбум төгрөг зэрэг томоохон төслүүдийг дурдаж болохоор байна.

1.4 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй нийт 16 төсөлд 271.5 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан нь “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан 2016 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний 2.0 хувийг эзэлж байна.

1.5 Хөтөлбөрт тусгагдсан ТАХ хэрэгжих боломжгүй байгаа нь хөтөлбөрт тавигдах шалгуур, төлөвлөлтийн аргачлалыг өөрчлөх шаардлагатайг харуулж байна.

Төлөвлөлтийн горимын алдааг арилгах, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад баримтлах нэгдсэн аргачлал шаардлагатай байна

1.6 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу ТЕЗ-даас ирүүлсэн саналыг

⁵ 28.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.

үндэслэн 2016 оны төсвийн хязгаарыг боловсруулж, Засгийн газрын 2015 оны 262 дугаар тогтоолоор 16 ТЕЗ-ийн хөрөнгийн зардлын хязгаарыг 234.8 тэрбум төгрөгөөр баталсан байна.

1.7 Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас 2015 оны 7 дугаар сард ТЕЗ нарт 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж хүргүүлсэн байна. Удирдамжид УИХ-аас баталсан 2016 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн Засгийн газраас баталсан төсвийн хязгаар, дунд хугацаанд баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангах чиглэл баримтлахыг ТЕЗ-дад үүрэг болгожээ.

1.8 ТЕЗ-дын 2016 оны төсвийн төсөлд ирүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн санал батлагдсан төсвийн хязгаараас хэд дахин давж, зураг, төсөв нь хуулийн шаардлага хангаагүй ТАХ-г шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4⁶-т заасныг баримтлалгүйгээр “хүслийн жагсаалт” гарган хүргүүлдэг хэвээр байгааг харуулж байна. Тухайлбал,

- БСШУСЯ-ны 2015 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 1А/7355 дугаар албан бичгээр 2016 оны төсвийн төсөлд 1,217.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 856.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 813 ТАХ хэрэгжүүлэх санал хүргүүлсэн нь төсвийн хязгаараас 13.1 дахин давсан бөгөөд шинээр 288 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 209 ТАХ-д нь зураг, төсөл хийгдээгүй,
- ЗТХЯ-наас 4,887.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээг 1,932.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх санал хүргүүлсэн нь төсвийн хязгаараас 36.4 дахин их,
- ХАХНХЯ-наас 65.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г 51.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн нь төсвийн хязгаараас 9.8 дахин их,
- ЭХЯ-наас улсын төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтээр нийт 951.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2016 онд 307.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх санал хүргүүлсэн нь төсвийн хөрөнгийн зардлын хязгаараас 379.2 дахин их байна.

1.9 Түүнчлэн төсвийн хязгаар батлагдаагүй 5 ТЕЗ-ийн багцад 28.2 тэрбум төгрөгийн хөрөнгийн санхүүжилт батлагджээ.

1.10 Улсын төсвийн төсөл бэлтгэх төсөвлөлтийн нэгдсэн аргачлал боловсруулагдаагүй, ТЕЗ-д салбарын хэмжээний хөрөнгө оруулалтын бодлого, урт болон дунд хугацааны хөтөлбөрөө боловсруулах, хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмблэж, төлөвлөх талаар санал санаачилга дутмаг ажиллаж байна.

1.11 ТЕЗ-дын төсвийн төсөлд өргөн барьсан төслүүдийг Төсвийн тухай хуулиар батлагдсантай харьцуулахад 106.8 тэрбум төгрөгийн 79 ТАХ хасагдаж, 97.1 тэрбум төгрөгийн 35 төсөл УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдэж батлагдсан байна. Тухайлбал,

ЗТХС-ын багцад:

- Хэнтий аймгийн Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын их засварын 7,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,
- АСЕМ-ын чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах зориулалттай Иргэний нисэхийн ерөнхий газрын тоног төхөөрөмж худалдан авах 13,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,

ЭХС-ын багцад:

- Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл /Увс, Өлгий сум/, 231.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,
- Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Баян-Өлгий, Өлгий сум/ 995.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г 2016 онд шинээр хэрэгжүүлэхээр тус тус нэмж баталсан байна.

1.12 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан нийт 68 зорилтыг хэрэгжүүлэхэд 1,175.7 сая ам.доллар, 1,405.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэж төлөвлөснөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 235.4 тэрбум, Хөгжлийн банкны санхүүжилтээр 125.7 тэрбум төгрөгийн ажил хийгдэхээр байна.

1.13 Харин Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар 16 төсөл, арга хэмжээнд 137.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан нь эдийн засаг, нийгмийг 2016 онд

⁶ ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах

хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан улсын төсөв болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 38.0 хувийг эзэлж байна.

1.14 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар нийт 3,546.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 627 хөрөнгө оруулалтын ТАХ-нд 796.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, хуульд 2016 оны 9 дүгээр сард оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 5,063.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 816 ТАХ-ний санхүүжилтэд 1,358.8 тэрбум төгрөг зарцуулагдахаар баталсан байна. (Дэлгэрэнгүйг хүснэгтээр 4-өөр харуулав)

Хүснэгт 4. Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт (тэрбум төгрөг)

Хөрөнгө оруулалтын ангилал		Төсвийн тухай хууль (2015.11.13-нд батлагдсан)			Хуулийн нэмэлт, өөрчлөлт (2016.09.09-нд батлагдсан)			Зөрүү нэмэгдсэн (+), хасагдсан (-)		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Хөрөнгө оруулалт	шинэ	31	118.0	47.5	31	156.9	42.9	-	38.9	(4.6)
	шилжих	509	3,103.5	644.2	666	4,390.9	1,120.2	157	1,287.4	476.0
Концесс эргэн төлөлт		2	11.6	5.8	3	108.8	70.7	1	97.2	64.9
Их засвар	шинэ	12	80.8	31.3	14	81.0	38.5	2	0.2	7.2
	шилжих	19	60.1	6.6	23	105.3	12.7	4	45.2	6.1
Тоног төхөөрөмж	шинэ	17	42.5	37.7	18	43.6	36.1	1	1.0	(1.6)
	шилжих	29	103.7	17.8	49	135.0	27.2	20	31.3	9.4
Зөвлөх үйлчилгээ		1	13.9	1.7	2	16.2	1.8	1	2.3	0.1
Төслийн нэгжийн зардал		1	8.0	1.9	1	8.0	1.2	-	0.0	(0.7)
ТЭЗҮ, зураг төсөл	шинэ				3	14.2	5.8	3	14.2	5.8
	шилжих	6	4.0	1.8	6	4.0	1.8	-	-	-
ДҮН		627	3,546.0	796.4	816	5,063.9	1,358.8	189	1,517.9	562.5

Эх сурвалж: Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль, хуулийн нэмэлт өөрчлөлт

1.15 Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ТАХ-ний тоо 189 буюу 30.1 хувиар, төсөвт өртөг 1,517.8 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар, санхүүжих дүн 562.5 тэрбум төгрөгөөр буюу 70.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.

1.16 Энэ нь УИХ-аас Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дараах бодлогын чиглэл баримталсантай холбоотой байна. Үүнд:

- 2015-2016 онд векселиэр олгосон санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын хавсралтаар батлан арилжааны банкинд төлөх өрийн асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсөнөөс тодотголоор шилжих 157 хөрөнгө оруулалтын, 4 их засварын ажил, 20 тоног төхөөрөмж худалдан авах 20 ТАХ нэмэгдэж батлагдсан байна.
- Мөн 2017 оноос эхлэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлбөрт вексель бичихгүй байх,
- УИХ-ын 2016 оны 81, Засгийн газрын 2016 оны 298 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хэрэгжиж байгаа ТАХ-г 2017 оноос зогсоож, нэг төсөвтэй болох бодлого баримталсан байна.

1.17 Төсвийн хөрөнгө оруулалтын 2016 оны санхүүжилтийн 90.9 хувийг шилжих 750 ТАХ, 9.1 хувийг шинээр эхлүүлэх 66 ТАХ тус тус эзэлж байна.

Дүрслэл 2. ТАХ-ний бүтэц (тоо, хувь)



Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийн 75 хувийг дэд бүтцийн салбарт хуваарилжээ

1.18 Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичгийн 5.1.1-д “Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт болон төсөв санхүүгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж, санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг дэмжихэд бүрэн чиглэнэ” гэж заасны дагуу 2016 онд төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрийг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд түлхүү хуваарилсан байна. (Дэлгэрэнгүйг хүснэгтээр 5-аар харуулав)

Хүснэгт 5. Санхүүжилтийн эх үүсвэр салбараар (тэрбум төгрөг)

Салбарын ангилал	Улсын төсөв	Векселийн эргэн төлөлт	Концесс	Хөгжлийн банкны санхүүжилт	НИЙТ	Эзлэх хувь
Дэд бүтэц	88.3	549.2	70.7	310.9	1,019.1	75.0
Боловсрол, шинжлэх ухаан, соёл	116.0	54.4			170.4	12.5
Эрүүл мэнд	47.4	16.1			63.5	4.7
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	24.8	12.0			36.8	2.7
Төрийн төв байгууллагууд	16.1	19.3			35.4	2.6
Батлан хамгаалах, хууль, хүчний байгууллага	9.3	13.7			23.0	1.7
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн	1.7	8.2			9.9	0.7
Хүнд үйлдвэр				0.7	0.7	0.1
ДҮН	303.6	672.9	70.7	311.6	1,358.8	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль, хуулийн нэмэлт өөрчлөлт

Төсвийн тухай хуульд төлөвлөлтийн алдаатай, хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасаар байна

1.19 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, ангилал, нэр, эхлэх хугацааг зөрүүтэй баталж байгаа нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, хугацаа алдах нэг шалтгаан болж байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад харьяа байгууллага, нэгжийн саналд тусгагдаагүй:

- Салбарын их засварын ажлын жагсаалтад орон нутгийн салбар нэгжээс ирүүлсэн саналд тусгагдаагүй сургуулийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сайхан сум/ - 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй,
- 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник, хана хүчитгэл засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ - 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд батлагдаж, эрх шилжсэн нь төлөвлөлтийн бодлого алдаатай байгааг харуулж байна.

Хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөөгүй:

- Хөвд аймгийн Манхан суманд баригдсан 500 хүний суудалтай 2.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй спорт цогцолборын барилгыг хүн ам олноор оршин суудаг⁷ аймгийн төвд барьсан бол хөрөнгө оруулалтын өгөөж илүү байхаар харагдаж байгаа бөгөөд уг барилгын ашиглалтын зардал сумын төсөвт ачаалал үүсгэхээр байна.

Ангилал зөрүүтэй:

- БСШУСС-ын багцын их засварын ажлын жагсаалтад сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 33 дугаар сургууль/, цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ гэсэн барилга, байгууламжийн арга хэмжээг оруулсан,
- ХНХС-ын багцад шинээр хэрэгжих 656.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах 2 ТАХ, 177.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй эд хогшил худалдан авах 3 ТАХ-г шилжих арга хэмжээгээр тусгасан,

Нэр, байршил зөрүүтэй:

- Гаалийн ерөнхий газарт хэрэгжиж буй “Замын-Үүдийн хилийн боомтын 11 км замын 48.0 мянган м.кв талбайн өргөтгөл”-ийн 2,113.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг ЗТХС-ын багцад баталсан,
- Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан Засгийн газрын 2015 оны 313, 328 дугаар тогтоолын хүрээнд хийгдэх Төв аймгийн “Хөшигийн хөндийн авто зам, гудамж төсөл”-д Сүхбаатар аймгийн төвд 2015 онд хэрэгжсэн “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын

⁷ Хүн амын тоо 2015 оны байдлаар Жаргалант сум 27,880, Булган сум 9,381, Манхан сум 4,067 байна. Эх сурвалж: <http://1212.mn>

7 уулзварыг өргөтгөн шинэчлэх болон төв замын засвар шинэчлэл"-ийн 2,249.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, 2016 оны 8 дугаар сард гэрээ байгуулан, ажил эхлүүлсэн "Аймгийн төвийн 3 дугаар тойргийн 7 км хатуу хучилттай авто зам"-ын 4,856.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг хамруулсныг Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр залруулсан.

1.20 Тайлант онд шинээр эхлүүлэх нийт 32.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ТАХ-ний техникийн нөхцөл гараагүй, зураг төсөл бэлэн болоогүй зэрэг хуулиар тогтоосон төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь жил бүр давтагдан гардаг зөрчлүүдийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байгаатай холбоотой буюу төлөвлөлтийн шатанд өөрчлөлт, шинэчлэлт хийх шаардлагатайг харуулж байна. Үүнд:

БСШУСС-ын багцад:

- Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх, 33 дугаар сургууль/ төсөвт өртөг 900.0 сая,
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар, Монгол-Оросын хамтарсан 3 дугаар дунд сургууль/ төсөвт өртөг 3,988.5 сая,
- Сургуулийн барилга, спорт заал /Завхан, Цэцэн-Уул сум/ төсөвт өртөг 1,700.0 сая,
- Хүүхдийн оюуны спортын ордон /Увс, Улаангом сум/ төсөвт өртөг 470.0 сая,
- Сургуулийн өмнөх насны зорилтот бүлгийн тусгай цэцэрлэг, 75 ор /Увс, Улаангом сум/ төсөвт өртөг 680.0 сая,
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан/ төсөвт өртөг 900.0 сая,
- Боловсролын салбарын барилга байгууламжийн өргөтгөл, их засварын 9,200 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд,

ЗТХС-ын багцад:

- Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын их засвар /Хэнтий/ төсөвт өртөг 7,500.0 сая,
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, 4.312 км /Ховд, Жаргалант/ төсөвт өртөг 2,529.5 сая,

ЭХС-ын багцад:

- Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл /Увс, Өлгий сум/ төсөвт өртөг 231.0 сая,
- Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Баян-Өлгий, Өлгий сум/ төсөвт өртөг 995.0 сая,

Шадар сайдын багцад:

- Аерах, гал унтраах 57 дугаар ангийн барилга /Завхан, Тэс сум/ төсөвт өртөг 190.0 сая,

ЭМС-ын багцад:

- Аймгуудын эрүүл мэндийн байгууллагын их засварын 3,521.2 сая төгрөгийн өртөгтэй ажлууд.

БОАЖС-ын багцад:

- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж байгаа хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа хийх 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудын зураг, төсвийг хараат бус экспертизээр хянуулаагүй байна.

1.21 Төсвийн тухай хуулиар төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн, иж бүрдэл болоогүй, эрх бүхий байгууллагаас бүрэн баталгаажуулаагүй зураг төсвөөр барилгын ажлыг эхлүүлж, үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1⁸, 23 дугаар зүйлийн 23.2⁹ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал,

ЭМС-ын багцад:

- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 3 дугаар шатлалын лабораторийн барилга угсралтын 10.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлаас 1.5 тэрбум төгрөгийн төсөвт магадлал хийгдээгүй,

ЗТХС-ын багцад:

- Завхан аймгийн Тосонцэнгэл сумын доторх 3 км хатуу хучилттай авто замын ажлын төсөвт өртөгийг 1.8 тэрбум төгрөгөөр санал хүргүүлсэн боловч хуульд 2.0 тэрбум төгрөгөөр батлагдсан,

ГХС-ын багцад:

- ГХЯ-ны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэлийн ажлыг 2013 оноос эхлэн 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд анхны төлөвлөсөн 12 давхар барилгын төсөвт өртөг 9.8 тэрбум төгрөгөөр баталгаажсан боловч төсвийн хөрөнгийн

⁸ 14.1 Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна. 14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх

⁹ Энэ хуулийн 23.1-д заасны дагуу баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна.


дутагдалтай байдлаас шалтгаалан одоогийн байдлаар 10 давхар барилга баригдаж, барилгын анхны зураг, төсөвт оруулсан өөрчлөлтөд магадлал хийлгэж, баталгаажуулалгүйгээр барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэсээр байна.

БХС-ын багцад:

- Говийн бүсийн сургалтын төв /Өмнөговь, Даланзадгад сум/ төслийн 2016 онд гүйцэтгэх ажлын 0.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгт магадлал хийгдээгүй,
- Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх /Улаанбаатар, Налайх дүүрэг/ 16.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг экспертиз, магадлалаар баталгаажуулаагүй зураг, төслөөр гүйцэтгэж байна.

1.22 Яамдуудад төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан ТАХ-нүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, чанарын ахиц дэвшлийг хэмжигдэхүйц байдлаар тоон үзүүлэлтээр нарийвчлан тооцоолж төлөвлөсөн судалгаа, тайлан, мэдээлэл алга байна.

1.23 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар аудитын явцад авсан санал асуулгын дүнгээр:



“Салбар хариуцсан яамд, төсвийн төсөл боловсруулагчид болон бусад оролцогч байгууллагууд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг төлөвлөлтийн шатанд хэрхэн тооцдог талаарх таны үнэлгээ” гэсэн асуулгад оролцогчдоос “Тооцдоггүй” гэж 29.0 хувь үзсэн бол 41.0 хувь буюу дийлэнхи нь “Тодорхой хэмжээгээр” тооцож ажилладаг гэж хариулсан байна. Харин “Тооцож” ажилладаг гэж 30.0 хувь нь үзсэн ч ТАХ-ний үр ашиг, үр өгөөжийг тооцдоггүй гэсэнтэй ойролцоо түвшинд хариулагдсан нь анхаарал татахаар байна.

1.24 Энэ нь хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөлт, төсөвлөлт Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй байхад сайжруулах, бодитой болгох, салбарт нэн шаардлагатай арга хэмжээг тусгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй ажил хариуцсан ажилтан, шийдвэр гаргагч нарт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатайг харууллаа.

1.25 ТАХ-ний санхүүжих дүн, хэрэгжих хугацааг харилцан уялдаатай төлөвлөхгүй байгаа нь төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжихгүй байх, ашиглалтад орох хугацаа хойшлох зэргээр хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Өртөг өндөртэй зарим арга хэмжээг жишээ болгон дурдвал,

- Дархан-Уул аймгийн төвд баригдаж буй спорт цогцолборын ажил 2011 онд эхэлсэн бөгөөд 20.6 тэрбум төгрөгийн гэрээтэй, 12.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, 2019 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн боловч 2016 онд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан,
- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт баригдаж буй Үндэсний номын сангийн барилгын 12.0 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон боловч 2017 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн уг арга хэмжээнд 2016 онд 0.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан.

1.26 Төсвийн тухай хуулиар өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 13 ТАХ-ний төсөвт өртөг 12.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь 5 төслийн хэрэгжих хугацаа удааширснаас төсөвт өртөг нэмэгдсэнээс 4.1 тэрбум, 5 ТАХ-ний зураг төсөлд суугаагүй нэмэлт ажилд магадлал хийгдсэнээс 6.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин 3 ТАХ-ний төсөвт өртгийг тодорхой шалтгаангүйгээр 1.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснийг 2017 оны Төсвийн тухай хуулиар залруулсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 7-оос харна уу)

1.27 Зарим ТАХ-ний санхүүжих дүн Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан дүн, гэрээний үнийн дүнгээс илүүгээр батлагдсан байгааг залруулах шаардлагатай байна. Тухайлбал,

- Говь-Алтай аймгийн Тайшир сумын соёлын төвийн барилгын 2017 онд санхүүжих дүнгээс 250.0 сая төгрөгийг хасах,
- Говь-Алтай аймагт баригдаж буй 500 суудалтай “Алтай чуулга”-ын барилгын 2017 онд санхүүжих дүнд 323.9 сая төгрөг батлагдсаныг 245.0 сая төгрөг болгож залруулах шаардлагатайг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт танилцуулав.

Худалдан авах ажиллагааны ил тод байдал бүрэн хангагдахгүй байна

1.28 Тайлант онд шинээр 66 ТАХ хэрэгжүүлэхээр батлагдсанаас ХААГ 44, ТЕЗ нар 4, харьяа байгууллагуудад эрх шилжүүлж 6, орон нутагт эрх шилжүүлж 11 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

1.29 ХАА-ны дүнгээр байгуулсан нийт гэрээний 55.4 хувийг нээлттэй, 2 2.8 хувийг харьцуулалтын, 2.8 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын, 19.0 хувийг шууд гэрээ байгуулах аргаар байгуулсан байна.

1.30 Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 455 дугаар тогтоолоор ХААГ-т 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 11 ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын шинэ 15, шилжих 11, тоног төхөөрөмж худалдан авах 6, их засварын 4, нийт 61.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих 11.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний ХАА-г шуурхай зохион байгуулахыг даалгаснаас Засгийн газрын 2016 оны 82 дугаар тогтоолоор өөрчлөлт орж, ХНХС-ын багцын 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 арга хэмжээ хасагджээ.

1.31 ХААГ-аас өмнөх онд гэрээ байгуулагдсан 6, ТЕЗ-даас хасуулах санал ирүүлсэн 6 ТАХ-г хасч, бусад ТЕЗ-даас эрх шилжиж ирсэн 13 ТАХ-г нэмж, нийт 33.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 44 ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан байна.

1.32 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 38 дугаар тогтоолоор эдийн засаг, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэй төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор:

1.2-т “2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зарлахгүй, гэрээ байгуулахгүй байх”

1.3-т “2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс өмнө гэрээ байгуулсан боловч худалдан авалт нь эхлээгүй арга хэмжээний санхүүжилтийг зохих журмын дагуу зогсоох”

1.4-т “2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон Хөгжлийн банкны санхүүжилтээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр санхүүжих хөрөнгө оруулалтын ТАХ-ний худалдан авах ажиллагааг шинээр зохион байгуулахгүй байх”

1.5-д “2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар гэрээ нь байгуулагдаагүй, ажлын гүйцэтгэл гараагүй, удаашралтай байгаа барилга байгууламжийн санхүүжилтийг хойшлуулах”-ыг даалгасан ч зарим ТЕЗ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал,

- ХНХС-ын багцад Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн НДХ-т тавилга, эд хогшил худалдан авах 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажлын,
- ЗТХС-ын багцад АСЕМ-ын чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах ИНЕГ-ын тоног төхөөрөмж худалдан авах ажлын 17 багц 2,790.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гэрээг 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс хойш байгуулсан.

1.33 Тайлант онд нийт гэрээний 68.6 хувийг оны эхний хагаст байгуулсан нь өмнөх оныхоос 5.9 хувиар нэмэгдсэн байна.

Дүрслэл 3. Гэрээ байгуулсан хугацаа (сар, хувь)



Эх сурвалж: УАГ-ын судалгаа

1.34 ТЕЗ-д эрх шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер оройтож зарлагдаж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8¹⁰-д заасныг зөрчиж, улирлын чанартай барилга угсралтын ажлын талбай дээр ажиллах, тоног төхөөрөмж, эд хогшлыг бэлтгэн нийлүүлэх хугацаагүй болж, цаашилбал хугацаандаа хэрэгжих боломжгүй байдалд хүргэсээр байна. Тухайлбал,

ХНХС-ын багцад:

- Говьсүмбэр аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн байр худалдан авах ажлын тендер шалгаруулалтад 210 хоног, Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн Хөдөлмөрийн нөхцөлийн лабораторийн байр худалдан авах тендер шалгаруулалтад 180 хоног,
- Тавилга эд хогшил худалдан авах арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг ХАА-ны төлөвлөгөөнд заасан хугацаанаас оройтуулсан,
- Өмнөговь аймагт хэрэгжих ТАХ-ний үнэлгээний хороог 2016 оны 8 дугаар сарын 24-нд байгуулсан,
- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт тавилга нийлүүлэх ТАХ-ний эрхийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/289 дугаар тушаалаар шилжүүлж, үнэлгээний хороо 2016 оны 11 дүгээр сарын 16-нд байгуулж, гэрээг 2016 оны 12 дугаар сарын 2-нд байгуулсан.

ЭМС-ын багцад:

- Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн дээврийн их засварын ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 14-нд эрх шилжүүлсэн,
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Номт хан өрхийн эмнэлгийн их засварын ажлыг 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар эрх шилжүүлсэн,

БСШУСС-ын багцад:

- Архангай аймгийн Өлзийт сумын цэцэрлэгийн их засварын ажлын эрхийг 2016 оны 11 дүгээр сарын 8-нд шилжүүлсэн,
- Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын дотор гэрэлтүүлгийн шинэчлэлт, 6 дугаар цэцэрлэгийн барилгын фасад, шат довжоо, цахилгааны засвар, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн дотор сантехник засварын ажлуудыг 2016 оны 10 дугаар сарын 20-нд эрх шилжүүлсэн,
- Увс аймгийн 1 дүгээр цогцолбор сургуулийн сантехникийн засварын ажлын эрхийг 2016 оны 9 дүгээр сарын 1-нд, Өлгий сумын сургуулийн засварын ажлын эрхийг 2016 оны 12 дугаар сард шилжүүлсэн,

Нэр байршлыг сольж хэрэгжүүлсэн:

- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 2, 5 дугаар цэцэрлэгүүдийн дээврийн их засварын нийт 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч уг ажлыг Япон Улсын “Өвсний үндэс хөтөлбөр”-ийн санхүүжилтээр хийх болсон тул БСШУСС-ийн 2016 оны А/120 дугаар тушаалаар нэр, байршлыг өөрчилж, Ногооннуур сумын сургуулийн хичээлийн байрны хаалга, цонхыг шинэчлэх, Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн ажилд зарцуулсан байна.

ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд өгсөн үнэлгээ өмнөх оноос 2.7 пунктээр буурчээ

1.35 Сангийн яамны “Худалдан авах ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний систем”-д нийтлэгдсэн тендерийн үр дүн, “e-procurement.mof.gov.mn” сайтад байршуулсан тендерийн урилга болон ирсэн гомдлын судалгаанд үндэслэн ТЕЗ-дын 2016 оны ХАА-ны хэрэгжилтэд өгсөн дундаж үнэлгээ өмнөх оныхоос 2.7 пунктээр, сүүлийн 3 жилийн дунджаас 8.0 пунктээр тус тус буурсан байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 6-аар харуулав)

Хүснэгт 6. ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны үнэлгээ (хувь)

ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны үнэлгээ							ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны үнэлгээ						
№	ТЕЗ	2016					№	ТЕЗ	2016				
		2013	2014	2015	Хувь	Үнэлгээ			2013	2014	2015	Хувь	Үнэлгээ
1	УЕП	56	82.5	74	80	Сайн	12	ХААГ	65	64	58	45.5	Хангалтгүй
2	УДШ	80	-	-	80	Сайн	13	ХХААХҮС	67	64	40	40	Хангалтгүй
3	УИХД				76	Хангалттай	14	ХНХС	56.5	69.8	59	42	Хангалтгүй
4	ШЕЗ	80	-	61	64	Хангалттай	15	Шадар сайд	48	61	50.5	38	Муу
5	УУХҮС	60	71	60	66.9	Хангалттай	16	ЭМС	31	69.5	60	37	Муу
6	ГХС	68	60	35	61.3	Хангалттай	17	БОНХАЖС	74	80	49	35	Муу
7	ХЗДХС	75	85	62	60	Хангалттай	18	ЗТХС	48	51	36.5	33	Муу

¹⁰ 46.1.8-д барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх.

8	СС	60	62.2	62	60	Хангалттай	19	БХС	62	61	35	25	Муу
9	ЗГХЭГ	86	-	-	60	Хангалттай	20	БСШУСС	0	48	46	25	Муу
10	МУЕА	40	72	53.5	46	Хангалтгүй	21	БХБС	51	55	37	23	Муу
11	ЭХС	51	78	60	46	Хангалтгүй							
ДУНДАЖ ХУВЬ									62	58.8	52.4	49.7	

Эх сурвалж: Сангийн яам

1.36 Худалдан авах ажиллагааны тайланг 2016 онд нийт 54 ТЕЗ бэлтгэхээс 4 буюу БХС, ЕТГ, СЗХ, ҮХЦ-ийн ТЕЗ тайлангаа хүргүүлээгүй, 8 ТЕЗ тухайн онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

1.37 ТЕЗ-д 2016 онд худалдан авах ажиллагааны 2951 урилга цахим сүлжээнд байршуулснаас 19.7 хувь буюу 582 үр дүнг нийтэлсэн нь олон нийтэд мэдээлэх чиглэлээр “хангалтгүй” ажилласныг харуулж байна.

1.38 Сангийн яам 20 ТЕЗ, ХААГ-ын худалдан авах ажиллагаанд үнэлгээ өгснөөс 57.2 хувьд “хангалтгүй” үнэлгээ өгсөн байна.

1.39 Мөн тус яаманд ХАА-ны гүйцэтгэгч сонгон шалгаруулахтай холбоотой нийт 606 гомдол ирсэн нь өмнөх оноос 3.4 хувиар нэмэгджээ. Нийт ирсэн гомдлын 49.8 хувь буюу 302-т захиалагч буруу шийдвэр гаргасан тул тендерийг дахин зохион байгуулах, үнэлгээг дахин хийх шийдвэр гарсан байна. Өмнөх онтой харьцуулахад захиалагчийн гаргасан буруу шийдвэрийн тоо 9.0 хувиар нэмэгдсэн нь ТЕЗ-даас үнэлгээний хорооны шийдвэрт тавих хяналт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

1.40 Нийт ирсэн гомдлоос улсын төсөв, Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын төсөлтэй холбоотой 271 гомдол бүртгэгдсэнээс 152 буюу 56.7 хувьд тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, үнэлгээг дахин хийх шийдвэр гарсан байна.

1.41 ЗТХЯ 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлээгүй, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.5¹¹-д заасан үүргээ биелүүлээгүй байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмын холбогдох заалтыг бүрэн мөрдөхгүй байна

1.42 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөлүүдийг хангаагүй байхад Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 12 болон 2015 оны 4 дүгээр сарын 27, 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн дараах төслүүдийн нэмэлт ажилд шууд гэрээ байгуулжээ. Үүнд:

- Архангай аймгийн Эрдэнэбулган суманд баригдаж буй 636.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга угсралтын ажилд 245.9 сая,
- Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Хонхор тосгоны эмнэлгийн барилга, гадна тохижилт, гараж, гүний худаг гаргах 577.2 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд 160.0 сая,
- Булган аймгийн Булган сумын 50 ортой төрөх эмнэлгийн 1,489.6 сая төгрөгийн гэрээт ажилд 671.0 сая,
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрүүл мэндийг дэмжих төвийн 647.5 сая төгрөгийн гэрээт ажилд 2 удаагийн нэмэлтээр 456.3 сая,
- Төв аймгийн Борнуур сумын 15 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх 567.6 сая төгрөгийн гэрээт ажилд 311.0 сая,
- Завхан аймгийн Улиастай суманд баригдаж буй 320 суудалтай Дэвшил сургуулийн барилгын өргөтгөлийн 1,569.5 сая төгрөгийн гэрээт ажилд 711.5 сая төгрөгийн нэмэлт гэрээг тус тус байгуулсан байна.
- Ховд, Баян-Өлгий аймгийн төвүүдийн хатуу хучилттай авто замын шинэчлэлийн ажилд авто замын засвар арчлалтын компаниудтай шууд гэрээ байгуулсан байна.

1.43 Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан тендерийн жишиг баримт бичигт зарчмын чанартай өөрчлөлт¹² оруулж гэрээ байгуулах эрх олгох үед нийлүүлэх

¹¹ Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ;

¹² “Бараа нийлүүлэх тендерийн жишиг баримт бичиг” Тендерт оролцогчид өгөх зааварчилгааны “40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй”

барааны тоо хэмжээг нэмэгдүүлэх, тендер шалгаруулж гэрээ байгуулсны дараа нэмэлт худалдан авалт хийх, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр тендерийн хэмнэлтийг ашиглаж нэмэлт тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт болон Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.26¹³-д заасан заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багцын Оюутан театрын тоног төхөөрөмжийн шинэчлэл /СУИС/ ТАХ-ний тендер шалгаруулалтад “Электрон техник” ХХК 197.1 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн бөгөөд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд барааны тоо хэмжээг нэмэгдүүлж, 216.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан,
- ХНХС-ын багцын салбарын хэмжээнд тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Ай Ти Зон” ХХК шалгарч 1,734.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн боловч 15.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлтээр нэмэлт гэрээ байгуулж тоног төхөөрөмж худалдан авсан,
- БСШУСС-ын багцын 100.0 сая төгрөгийн төсөв бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, тавилга, 327.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сургуулийн өмнөх боловсролын байгууллагын компьютер, техник хэрэгсэл худалдан авах 2 ажлын тендерийн хэмнэлт 95.9 сая төгрөгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан,
- ЭХС-ын 2014 оны 112 дугаар тушаалаар “Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах” ажлын хэмнэлт 351.1 сая төгрөгийг 12 багц ажилд, “Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт” ажлын хэмнэлт 446.1 сая төгрөгийг 9 багц ажилд хуваан нэмэлт ажлын гэрээ байгуулж нэмэлт гэрээний санхүүжилтийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх ажлын жагсаалтад батлуулан санхүүжүүлсэн,
- ЭМСС-ын багцад 2,189.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендерийн хэмнэлт 57.6 сая төгрөгийг дахин хуваарилсан,
- ЗГХЭГ-ын даргын багцаас Төв аймагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөгийн ажилд худалдан авах ажиллагааны үр дүнгээр 79.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 20.2 сая төгрөгийн хэмнэлт үүссэнээс 16.0 сая төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулсан.

1.44 Босго үнэд багтаах, шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хэт жижиглэн олон багцад хувааж гүйцэтгүүлж байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁴, 8.5¹⁵ дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- Дархан-Уул аймгийн нийтийн орон сууцны байрны инженерийн шугам сүлжээний 23.7 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 4 багцад хувааж, “Толбот хайрхан” ХХК-аар,
- Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын байрны коридор, өрөө тасалгааны засварын 61.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 4 багцад хувааж тус тус гүйцэтгүүлсэн.

1.45 Зарим тендер шалгаруулалтыг явуулах худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо Засгийн газраас тогтоосон босго үнийг баримтлаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2¹⁶ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

- Төв аймгийн Архуст сумын Эрүүл мэндийн төвийн 212.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын,
- ЗГХЭГ-ын даргын багцаас Увс аймагт эрх шилжиж ирсэн Зүүнхангай сумын ЗДТГ-т орон сууц худалдан авах 60.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг тус тус харьцуулалтын аргаар сонгосон байна.

1.46 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад гарсан зөрчлүүд нь ТЭЗ-дын байгуулсан үнэлгээний хороодын ажилтнуудын хүлээх чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо үйлчлэхгүй байгаатай холбоотой байна.

¹³ Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам 3.26 “Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч ашиглахгүй”

¹⁴ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

¹⁵ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

¹⁶ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

Бүлэг 2 Оролцогч талуудын хариуцлага сул байгаагаас төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 90.5 хувьтай гарсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 8.1 хувиар нэмэгдсэн байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 7-оор харуулав)

Хүснэгт 7. 2016 онд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд олгосон санхүүжилт (тэрбум төгрөг, хувь)

Эх үүсвэрийн ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2016 онд санхүүжих	2016 оны гүйцэтгэл	Зөрүү	Хэрэгжилт, хувиар
Улсын төсвийн шууд хөрөнгө оруулалт	293	1,275.6	303.6	246.4	57.3	81.2
Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлсэн	109	1,336.7	311.6	252.8	58.8	81.1
Засгийн газрын векселийн эргэн төлөлт	411	2,342.8	672.9	659.5	13.4	98.0
Концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн ТАХ-ний санхүүжилт	3	108.8	70.7	70.7	-	100.0
НИЙТ	816	5,063.9	1,358.8	1,229.4	129.5	90.5

Эх сурвалж: Сангийн яам

2.2 Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ихэнх ТЕЗ ашиглаж чадсан бол Ерөнхий сайд, ЭХС, Сангийн сайдын багцад 80-аас доош хувийн ашиглалттай байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 8-аар харуулав)

Хүснэгт 8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл (тэрбум төгрөг, хувь)

№	ТЕЗ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	№	ТЕЗ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	УУС	0.7	0.7	-	100.0	11	ЗГХЭГ	3.2	2.9	0.3	89.1
2	УЕП	1.5	1.5	-	100.0	12	УИХД	0.7	0.6	0.1	88.6
3	МУЕА	0.5	0.5	-	99.7	13	ЭМС	63.6	55.8	7.8	87.7
4	ХЗДХС	15.5	15.4	0.2	98.9	14	ХХААХҮС	8.9	7.6	1.3	85.3
5	БОАЖС	1.0	1.0	-	98.1	15	БХС	5.9	4.9	1.0	82.3
6	ХНХС	36.8	35.6	1.2	96.7	16	СС	10.9	8.6	2.3	79.2
7	МУШС	9.7	9.4	0.4	96.1	17	ЭХС	187.7	146.7	41.0	78.2
8	ЗТХС	709.8	668.1	41.7	94.1	18	МУЕС	9.8	7.1	2.7	71.8
9	БХБС	121.6	110.2	11.4	90.7	19	ГХС	0.6	0.6	0	100.0
10	БСШУСС	170.4	152.3	18.1	89.4		ДҮН	1,358.8	1,229.4	129.5	90.5

Эх сурвалж: Сангийн яам


2.3 Хэрэгжиж буй нийт ТАХ-ний 76.7 хувь нь 4 жилээс дээш хугацаагаар үргэлжилж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах дундаж хугацаа 4.6 жил байна.

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын хэрэгжиж буй ТАХ-ний үргэлжилж буй хугацаа (жил, хувь)

Ангилал	Хэрэгжилтийн үргэлжилж буй хугацаа, жилээр												Нийт тоо
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Хөрөнгө оруулалт	13	40	78	104	380	49	23	5	9	2		1	704
Их засвар	9	6	1	1	17								34
Тоног төхөөрөмж	16	18	4	1	28								67
ТЭЗҮ, зураг төсөл, бусад	2		3	2	2	1	1						11
ДҮН	40	64	86	108	427	50	24	5	9	2	0	1	816
Эзлэх хувь	4.9	7.8	10.5	13.2	52.3	6.1	2.9	0.6	1.1	0.2		0.1	100
Барилга угсралтын ажлын ашиглалтад орох дундаж хугацаа, жилээр													4.6

2.4 Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 2016 онд 2,774.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 637 ТАХ-г иж бүрэн хэрэгжүүлж дуусгаагаар төлөвлөснөөс 565 ТАХ хугацаандаа хэрэгжиж, 217.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 57 арга хэмжээний хэрэгжилт дутуу, 33.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 8.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх 15 төслийн бэлтгэл ажлыг хангаагүйгээс хэрэгжээгүй байна.

2.5 Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ ихэнхдээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалтаас шалтгаалсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2, 4-өөс үзнэ үү)



2.6 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө газрын асуудлыг бүрэн шийдвэрлээгүй, техникийн нөхцөл аваагүй, тооцоо судалгааг иж бүрэн хийгээгүй зэрэг бэлтгэл ажлыг хангаагүйгээс дараах төслүүдэд батлагдсан хөрөнгийг ашиглаж чадаагүй байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багцад батлагдсан Япон, БНХАУ-ын буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдээр тодорхой ажлууд хийгдсэн боловч төлөвлөлтийн тооцоо судалгаа хангалтгүйгээс Монголын талын хөрөнгөд батлагдсан 600.0 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглаагүй,
- БСШУСС-ын тушаалаар баталсан салбарын байгууллагуудын их засвар, дээд боловсролын шинэчлэл зэрэг багц арга хэмжээний жагсаалтад тусгагдсан арга хэмжээний эрх шилжүүлэх ажлыг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс 205.0 сая төгрөгийн төсөв бүхий 2 ТАХ хэрэгжээгүй,
- ХНХС-ын багцад Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилгын газрын асуудал шийдэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

2.7 ХНХС-ын багцад Орхон аймгийн Баян-Өндөр суманд баригдаж буй “Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр”-ны барилга угсралтын ажлын гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 2015 онд цуцлагдаж, 2016 онд батлагдсан 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглагдаагүй буюу ТАХ хэрэгжээгүй байна. Уг ажлын гүйцэтгэгчээр ажиллаж байсан “Хасуу цамхаг” ХХК-д урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон санхүүжилтийн үлдэгдэл болон гүйцэтгэлийн баталгааны, нийт 889.1 сая төгрөгийг буцаан авч 2015 оны 12 дугаар сард тус яамны Төрийн сан дахь техник хяналтын зардлын дансанд байршуулсан боловч улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй тул төлбөрийн акт тогтоолоо.

2.8 ЗТХС-ын багцад Кувейтын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Уньт-Тариалан чиглэлийн 88 км хатуу хучилттай авто зам”-ын ажлыг гүйцэтгэгч БНСУ-ын “Beak Seok” компани гэрээний үүргээ биелүүлээгүй тул гэрээг 2014 онд цуцалсан бөгөөд ЗТХС-ын барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй үлдэгдэл санхүүжилт болох 866.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2.9 Улсын төсвөөс санхүүжүүлсэн 145.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 45, Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн 71.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 12, нийт 57 ТАХ-ний хэрэгжилт дутуу байгаагийн 36.8 хувь нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас буюу мэргэжлийн ажиллах хүчин, техник хэрэгслэлийн хүрэлцээгүй байдал, зохион байгуулалтын алдаанаас хугацаа алдсан, 21.1 хувь нь төсвийн хүндрэлээс шалтгаалж санхүүжилт хугацаандаа олгогдоогүй, 14.0 хувь нь захиалагч зураг, төсвийн өөрчлөлтийг хугацаанд нь хийгээгүй, газрын зөвшөөрлийн асуудлыг бүрэн шийдвэрлээгүй, техникийн нөхцөл аваагүй зэргээс шалтгаалсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1, 3-аас үзнэ үү)

Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна

2.10 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа нийт 11 ТАХ-ний гүйцэтгэлд Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.3¹⁷ дахь заалтыг зөрчиж илүү санхүүжилт олгосон, захиалагчийн барилгын ажлын үе шатны хяналт, ажлын хариуцлага хангалтгүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үлдэгдэл санхүүжилтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал,

¹⁷ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна.

Ажлын гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон:

- Баянхонгор аймгийн Шаргалжуут сумын 10 ортой, эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Алтайн газрын хүч”-д 516.0 сая,
- Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 50 ортой төрөх эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Лайт хаус капитал” ХХК-д 1,159.6 сая,
- Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 15 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Бэржин-Уньт” ХХК-д 67.7 сая,
- Дорноговь аймгийн Сайншанд сумын 50 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Мон Инж Бар” ХХК-д 770.7 сая,
- Говь-Алтай аймгийн Цээл сумын 10 ортой эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Гуулин тал” ХХК-д 281.9 сая,
- Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй Геронтологийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч “Арвис интернэйшнл” ХХК-д 1,676.3 сая,
- Говь-Алтай аймгийн Хүүхэд залуучуудын ордны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Арвин бэлт” ХХК-д 550.1 сая,
- Аймгийн төвүүдэд шинээр дулааны станц, дулааны шугам барих /Булган, 28МВт/ ажлын гүйцэтгэгч “Энержи плас” ХХК-д 300.0 сая,
- Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метрийн гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Меговатт” ХХК-д 1,311.0 сая,
- Дулааны шугамын өргөтгөл, дэд станц барилга угсралтын ажил /Булган/-ыг гүйцэтгэгч “Альяс-Тех” ХХК-д 42.1 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус бодит ажлын гүйцэтгэлээс илүүгээр олгосон байна.

Дутуу ажилд хариуцлага тооцоогүй:

- Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт баригдаж буй Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Суурь” ХХК-д 2010-2015 оны хугацаанд нийт 2,954.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч “Суурь” ХХК-ийн гүйцэтгээгүй ажлын санхүүжилт 436.2 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж иржээ

2.11 Захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон магадлашгүй ажлын актгүйгээр гүйцэтгэгч байгууллагад санхүүжилт олгосон нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3¹⁸, 3.13¹⁹ дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо. Тухайлбал,

- Завхан аймгийн Улиастай сумын 30 ортой Халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Зуурмаг” ХХК-д гэрээний үнийн дүнгээс давуулж санхүүжүүлсэн 20.1 сая,
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Биг монголиа билдинг” ХХК-д магадлашгүй ажлын зардалд 1.7 сая,
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Агни трейд” ХХК-д захиалагчийн техник хяналтын зардал 3.9 сая,
- Өмнөговь аймгийн Даланзадгад суманд баригдаж буй Говийн бүсийн сургалтын төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “БХАҮН” ТӨҮГ-т 6.2 сая,
- Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд нийслэлийн Налайх дүүрэгт баригдаж буй байгууламжийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Зэвсэгт хүчний дугаар ангид 14.6 сая,
- Нийслэлийн Алдар спорт хорооны Цэрэг спортын төв цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч Зэвсэгт хүчний дугаар ангид 10.9 сая төгрөгийг тус тус магадлашгүй ажлын актгүйгээр олгосон байна.

2.12 ХНХС-ын багцад БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн барилга”-ын Монголын тал хариуцах 2.0 тэрбум төгрөгийн өртөгтэй гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг гүйцэтгэгч “Инж байгууламж” ХХК нь инженер хангамжийн зураг төслийг мэргэжлийн байгууллагатай

¹⁸ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг, төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.

¹⁹ Төсвийн магадлашгүй ажлын зардлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон актын дагуу олгох бөгөөд актаар

зөвшилцөлд хүрээгүй үедээ магадлал хийлгэн баталгаажуулсан нь Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийлгэх дүрмийн 5.2²⁰ дахь заалтыг зөрчиж, зураг төсөл өөрчлөгдөн төсөл арга хэмжээний хэрэгжилт удаашрах шалтгаан болжээ.

2.13 Төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр төсөвт өртгийг нэмэгдүүлэн батлаагүй байхад Хөгжлийн банкнаас санхүүжилтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16²¹ дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- Засгийн газрын 2016 оны 53 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14²² -д заасныг үндэслэн Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2016 онд санхүүжүүлэх ТАХ-ний жагсаалтын 64, 65-д заасан хөрөнгийг мөн хавсралтын 67-д заасан “Аймаг, дүүргийн доторх гудамж, зам, талбайн тохижилт, шинэчлэл” /Улаанбаатар, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Ховд/ ажлыг санхүүжүүлэх, уг зохицуулалтыг төсвийн тодотголд тусгахыг Сангийн болон Зам тээврийн сайд нарт үүрэг болгосон байна. Уг тогтоолын дагуу нийслэлд эрх шилжсэн ажлуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хэрэгжүүлсэн боловч тухайн төслийн санхүүжих дүн нь төсөвт өртгөөс хэтэрсэн тул анх баталсан төсөвт өртгөөс хэтрүүлэн санхүүжүүлэх боломжгүй байдал үүсчээ. Төсвийн тухай хуулийн тодотголд дээрх арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэн батлаагүй байхад Хөгжлийн банкнаас 3.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2.14 БОАЖС-ын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд, мөн захиалагчийн техник хяналтыг гүйцэтгэхэд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулаагүй нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.9²³ дэх заалтыг зөрчсөн байна.

2.15 Барилга, угсралтын ажил эхлэх, байнгын ашиглалтад оруулах комисс ажиллах үед зохиогч оролцохоос бусдаар зохиогчийн хяналт иж бүрэн хэрэгжихгүй байх явдал нийтлэг байгаа нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5²⁴ -д заасантай нийцэхгүй, барилга угсралтын ажлын чанар, гүйцэтгэлд нөлөөлж байна.

2.16 Барилга угсралтын ажлын явц удаашралтай байх, гэрээт хугацаанд ашиглалтад орохгүй байгаагаас дараах ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээний нэмэлт зардал гарахад хүргэж, нэмэлт эх үүсвэр шаардагдаж байна. Үүнд:

- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто замын ажилд “МСРС gr” компанийн үзүүлж буй зөвлөх үйлчилгээний гэрээ дууссан,
- Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км авто замын ажилд “Мөнхөд ашдын зам” ХХК, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нарын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй төслүүдийг дурдаж болохоор байна.

2.17 Барилгын хөгжлийн төвөөс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ажлыг гүйцэтгэх чадваргүй гүйцэтгэгч компаниудын гэрээг цуцлах тухай саналыг БСШУСЯ-нд хүргүүлсэн боловч энэ талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Булган, Тэшиг сум/ гүйцэтгэгч “Төмөрхүлэг” ХХК,
- Сургуулийн барилгын комплекс, 320 суудал /Хөвсгөл, Улаан-Уул сум/ гүйцэтгэгч “Есүй ордон” ХХК

Захиалагч эрх мэдлээ хэтрүүлснээс төсвийн хөрөнгийг илүү үр ашигтай төсөл, арга хэмжээнд зарцуулах боломжийг алдагдуулж байна

²⁰ Зураг төслийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, барилгын нормативын баримт бичгийг баримтлан зөвшилцөнө. Тухайн байгууллагыг төлөөлж зөвшилцсөн этгээд нь хүснэгт 1-д заасны дагуу өөрт хамааралтай хэсгийн нүүр хуудас, ерөнхий өгөгдлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хуудсанд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

²¹ төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох

²² тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх

²³ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилга, их засварын ажил бүрийг биечлэн хянан шалгах үүрэг бүхий хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулах бөгөөд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компани нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргах бөгөөд барилга ашиглалтад орсоны дараа санхүүжилтийн материалын хамт захиалагчийн архивт хадгалуулна.

²⁴ Барилгын тухай хуулийн 37.1-д Барилгын ажлын захиалагч дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. 37.1.5-д барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

2.18 Захиалагч эрхээ хугацаа алдаж шилжүүлсэн, гэрээ оройтож байгуулсан, гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл тухайн оны санхүүжих дүнд хүрээгүй нөхцөлд ТЕЗ-д батлагдсан хөрөнгийг буцаан төвлөрүүлэхээс зайлсхийж үлдэгдэл санхүүжилтийг хуурамч гүйцэтгэлээр шилжүүлэн авч барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын дансанд байршуулсан нь хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдах, хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

- ГХС-ын багцад яамны өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгах 601.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан боловч гүйцэтгэгч ажлаа гүйцэтгээгүй 300.0 сая төгрөг,
- Архангай аймгийн Хангай сумын 320 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилгын ажлын 201.9 сая төгрөг,
- Архангай аймгийн Нийтийн номын сангийн засварын ажлын 15.1 сая төгрөг,
- Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн байрны дээврийн засварын ажлын 90.8 сая төгрөг,
- Говь-Алтай аймгийн Есөн булаг сумын “Хүүхэд залуучуудын ордон”-ы барилга угсралтын ажлын 262.6 сая төгрөг,
- Сэлэнгэ аймагт дуусаагүй болон чанарын шаардлага хангаагүй ажлыг комиссын актаар хүлээн авч үлдэгдэл 78.9 сая төгрөгийн санхүүжилтийг Төрийн сан дахь барьцаа хөрөнгийн болон техник хяналтын зардлын данс, Төрийн банкинд тус тус байршуулсныг аудитын явцад улсын төсөвт буцаан төвлөрүүлэх акт, албан шаардлага өглөө.

Захиалагчийн хяналтын зардлын ашиглалт, зарцуулалт хангалтгүй байна

2.19 ТЕЗ-дын захиалагчийн хяналт, техник хяналтын зардал²⁵-д хуримтлуулсан хөрөнгийн ашиглалт хангалтгүй, ашиглалтад орсон барилга, байгууламжийн техник хяналтын зардлын үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, зарим хэсгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2²⁶-д заасныг зөрчиж байгаа тул аудитаар 53.9 сая төгрөгийн төлбөрийн акт тавьж, 2,462.9 сая төгрөгийн албан шаардлагыг хүргүүллээ. Үүнд:

- ХНХС-ын техник хяналтын зардлын дансан дахь ашиглалтад орсон 4 барилга, байгууламжийн 27.3 сая,
- ЭХС-ын ашиглалтад орсон 4 барилга, байгууламжийн 14.2 сая,
- ЭМС-ын техник хяналтын зардлаас зориулалт бусаар зарцуулсан 12.4 сая төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэв.
- Завхан аймагт эрх шилжсэн ажлуудын техник хяналтын зардлын үлдэгдэл 94.8 сая төгрөгийг “хөрөнгө оруулалтын хяналт” данс шинээр нээн байршуулсан байна.
- ЗТХС-ын техник хяналтын дансан дахь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн хэрэгжиж, комиссын актаар ашиглалтад хүлээн авсан 10 ТАХ-ний техник хяналтын зардлын үлдэгдэл 2,462.9 сая төгрөгийн үлдэгдэл байгааг дараа онд зарцуулах шаардлагатай гэсэн тайлбар өгч байна.

2.20 Захиалагч хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийгээгүй байна. Тухайлбал,

- ХНХС-ын багцын хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилтэд гэрээгээр хяналт хийж буй “Их барилгын зөвлөх” ТББ-ын тэргүүн Төв аймгийн Батсүмбэр суманд баригдсан Асрамж хөгжлийн үндэсний төвийн нөхөн сэргээх сувилалын барилга гадна хашааны төсөвт өртгийн тооцооллыг өөрөө хийж, түүндээ хяналт тавьсан,
- Төв аймагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 4 төсөлд аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүд буюу мэргэжлийн бус ажилтнууд хяналт тавьсан зэргийг дурдаж болохоор байна.

Улсын комиссын үйл ажиллагаа шаардлагын түвшинд хүрэхгүй байна

2.21 Барилга, угсралтын ажил чанаргүй, дутуу хийгдсэн, гүйцэтгэгч байгууллага улсын комиссоос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байхад комиссын гишүүд хүлээн авсан актад гарын үсэг зурж дутуу ажлыг хүлээн авч байна. Энэ нь Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12.6²⁷-дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

²⁵ Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д заасны дагуу захиалагчийн хяналтын зардлыг барилга угсралтын ажлын дүнгийн 2 хувиар тооцон техник хяналтын дансанд төвлөрүүлж, хяналтын үйл ажиллагаанд зарцуулдаг.

²⁶ Төсвийн тухай хуулийн 45.2 Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ: 45.2.1.нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол

²⁷ Барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, засварын ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн, хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, техникийн нөхцөлийн заалтын шаардлага хангаагүй болон барилгын ажлын явц, чанарт тавигдсан хяналтад байгаа, тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ үзүүлсэн этгээд,

Говь-Алтай:

- Бигэр суманд баригдсан 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гадна бетон зам, тоглоомын талбай, дотор цэвэр, бохирын холболтын 26.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байхад ашиглалтад оруулсан,
- Соёл амралтын хүрээлэнгийн ажилд захиалагчийн хяналт хийгдээгүй, 3 багц ажлын гүйцэтгэлээс 18 төрлийн 70.4 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад улсын комисс хүлээн авсан,

Архангай:

- Өндөр-Улаан сумын сургуулийн спорт заалын барилгын цэвэр ус шахах насос хүлээлгэж өгөөгүй, гадна зам талбайн ажлаас явган замын өнгөт хавтангаар хийх 604.2 м.кв талбайг хийгээгүй, батлагдсан зургаас заалны гэрэлтүүлгийг өөр газар суурилуулсан, халаалтын шугамын хамгаалалт хийгдээгүй. Аймгийн Засаг даргын 2016 оны А/371 захирамжаар томилогдсон комиссын гишүүн сургуулийн захирал, менежер нарыг барилга хүлээн авахад оролцуулаагүй,

Хэнтий:

- Батширээт сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажлыг “Эрхэт наран” ХХК барьж гүйцэтгэн, 2016 оны 12 дугаар сарын 07-нд байнгын ашаглалтад хүлээж авсан боловч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй,

Завхан:

- Их-Уул, Тосонцэнгэл сумдын ЦДАШ-ын ажлыг улсын комисс хүлээн авсан боловч хэрэглэгчийн тоо хэт цөөн, гүйцэтгэгч “Жам” ХХК улсын комиссоос өгсөн үүргийг биелүүлээгүй шалтгаанаар хүчдэлд залгаадаагүй байна.

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

2.22 Орон нутагт багц болон задарсан нийт 120 ТАХ-г эрх шилжүүлэн хэрэгжүүлснээс гүйцэтгэгчийн хариуцлага сулаас ажлын чанар хангалтгүй, гэрээт хугацаанд гүйцэтгээгүй, зарим ажлын гүйцэтгэл дутуу байхад ашиглалтад оруулсан байна. Тухайлбал,

Чанаргүй гүйцэтгэсэн:

- “Елбата” ХХК-ийн гүйцэтгэсэн Баянхонгор аймгийн Баянговь сумын сургуулийн их засварын ажил, Гурванбулаг суманд дотуур байрны их засварын ажил,
- “Базардарь” ХХК-ийн гүйцэтгэсэн Баянхонгор аймгийн Шаргалжуут сумын Цагдаагийн кабон барилгын ажил,
- “Ган нэгдэл” ХХК гүйцэтгэсэн Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын засварын ажил,
- “Алтанбулаг трейд” ХХК-ийн гүйцэтгэсэн нийслэлийн Сүхбаатар дүүргийн 960 суудалтай 3 дугаар сургуулийн барилгын ажил,
- “Их богд оргил” ХХК-ийн гүйцэтгэсэн Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын цагдаагийн кабоны барилгын ажил,
- “Ган нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэсэн Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 4 дүгээр цэцэрлэгийн их засварын ажил,
- “Хайлааст гарам” ХХК-ийн гүйцэтгэсэн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн их засварын ажил,
- “МТМЖ” ХХК-ийн гүйцэтгэсэн Сэлэнгэ аймгийн Мандал сумын эмнэлгийн засварын ажил,
- “Хүдэнгийн уурхай” ХХК-ийн гүйцэтгэсэн Увс аймгийн Тэс сумын “Таван улиас” бага сургуулийн засварын ажил,

Ажлын гүйцэтгэл дутуу:

- Архангай аймгийн Өндөр-Улаан суманд “Макс майнд” ХХК-ийн гүйцэтгэсэн спорт заалны барилгын ажил,
- “Хоролбагана констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Баянхонгор аймгийн Баянбулаг сумын 10 ортой эмнэлгийн барилга ажил,
- “Нью эрхэм” ХХК-ийн гүйцэтгэсэн Увс аймгийн Малчин сумын тохижилтын ажил,

Гэрээт ажлыг хугаацаанд нь гүйцэтгээгүй:

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг “АТТА ЧР” ХХК,
- Завхан аймгийн Улиастай сумын спорт цогцолборын ажлыг “Эл Эс Би” ХХК,
- Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дотуур байрны засварын ажлыг “Фамилисон” ХХК,
- Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сургуулийн их засварын ажлыг “Нью гранд цамхаг” ХХК,
- Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сумдын Рашаант, Хуягт багуудад ЦДАШ барих ажлыг “Жам” ХХК,

- Өвөрхангай аймгийн Тарагт сумын 100 ортой дотуур байрны их засварын ажлыг “Өв од барилга” ХХК,
- Өвөрхангай аймгийн Хужирт сумын 100 ортой дотуур байрны их засварын ажлыг “Гүн чимэгтэй” ХХК,
- Говьсүмбэр аймагт Канад технологиор баригдаж буй 100 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг “Хялганат нуга” ХХК нар гэрээт хугацаанд гүйцэтгээгүй байна.

2.23 Захиалагчийн хяналтыг эрх шилжүүлэн авч хэрэгжүүлэгч Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.6²⁸-д заасныг зөрчиж, хугацаа хэтрүүлсэн гүйцэтгэгчтэй гэрээний хариуцлага тооцоогүй, хяналт тавих чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Тухайлбал,

Гэрээний нөхцөлд шаардлагатай заалтуудыг бүрэн тусгаагүй:

- Говь-Алтай аймагт 22 ажил эрх шилжиж ирснээс 15 ажлын гэрээнд төлбөр хийх нөхцөл хэлбэрийг үе шаттай тусгаагүй, 7 гэрээт ажилд захиалагчийн хяналтыг хэрхэн хийх талаар заалтгүй, 7 ажилд гүйцэтгэлийн баталгаа гаргах хугацаа тусгалгүйгээр гэрээ байгуулсан,

Ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй:

- Завхан аймгийн Асгат сумын сургууль, спорт заалны их засвар, Тэс сумын аврах, гал унтраах ангийн барилга худалдан авах, засварлах ажлуудын явцад хяналт тавилгүйгээр ашиглалтад хүлээн авсан,
- Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн их засварын ажилд 101.2 сая төгрөг батлагдсаныг 2013 онд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ашиглагч байгууллагын санаачлагаар хийгдсэн батлагдсан зураг, төсөвгүй, нэмэлт ажлын гэрээ байгуулагдаагүй, гүйцэтгэлийг нь хянаж баталгаажуулаагүй ажилд олгосон,
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги боомтын цагдаагийн хэсгийн байрны барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч “Шунхлайн шандас” ХХК ажлаа гүйцэтгээгүйгээс “Пазл Солюшн” ХХК-тай 2016 оны 12 дугаар сарын 18-нд шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч ажлыг зургийн дагуу гүйцэтгээгүй, дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон,
- Завхан аймгийн Богдын гол багийн 100 ортой цэцэрлэгийн барилга, Ахмадын болон амьдрах ухааны ордон, спорт цогцолборын барилга угсралтын ажлын үе шатны ажлын хуваарь алдаатай байхад ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулсан,
- Завхан аймгийн төвийн болон сумдын авто замын хэвтээ, босоо тэнхлэгийн тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэх ажлын гүйцэтгэлийг 2016 оны 7 дугаар сард 66.7 хувь, 2016 оны 8 дугаар сард 33.3 хувьтай гэж баталгаажуулсан ч бодит байдал дээр ажил хийгдээгүй,

Гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй:

- Дорноговь Замын-Үүд сумын 960 суудалтай сургуулийн барилга угсралтын ажил, Сайншанд сумын 3, 6 дугаар цэцэрлэгүүдийн засварын ажил, Хатанбулаг сумын Ханги боомтод баригдсан Цагдаагийн хэсгийн барилгын ажлууд,

Илүү санхүүжилт олгосон:

- Завхан аймгийн спорт цогцолборын ажлын гүйцэтгэгч “Эл Эс Би” ХХК –д 432.7 сая,
- Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сургуулийн их засварын ажлын гүйцэтгэгч “Нью гранд цамхаг” ХХК-д 10.6 сая,
- Төв аймгийн Баянцогт сумын цэцэрлэгийн засварын ажлыг гүйцэтгэгч “Титан оргил” ХХК-д 1.8 сая,
- Төв аймгийн Мөнгөнморьт сумын сургуулийн барилгын засварын ажлыг гүйцэтгэгч “Гарден сити” ХХК-д 2.5 сая,
- Төв аймгийн Борнуур сумын цэцэрлэгийн засварын ажлыг гүйцэтгэгч “Дуулгат мөрөн” ХХК-д 1.8 сая төгрөгийг тус тус илүү олгосон байна.

2.24 Эрх шилжүүлсэн зарим арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг хуурамч гүйцэтгэлээр гаргуулан авч, өөр дансанд байршуулж байгаа нь хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг үүсгэж байна. Тухайлбал,

- Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлгийн засварын ажлын 4.0 сая,
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн засварын ажлын 74.9 сая төгрөгийг тус тус аймгийн Төрийн сан дахь барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

2.25 ТЕЗ-даас орон нутагт 20.2 тэрбум төгрөгийн 159 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн боловч хэрхэн ашиглах талаар сургалт, зааварчилгаа өгөөгүйгээс ашиглалтгүй, хэрэгцээ шаардлагад тулгуурлан худалдан авалт хийгээгүйгээс илүүдэлтэй,

²⁸ 4.6-д Зураг төсөл зохиогч, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч талууд хамтран тухайн барилга байгууламжид техникийн болон чанарын үзлэг, шалгалт хийж дотоодын хяналтын дүгнэлт гаргана. Энэхүү дүгнэлтийг энэ дүрмийн 4.5-д заасан материалд хавсаргасан байна.

хөрөнгө болон тээвэрлэлт суурилуулалтын зардлыг өртөгт шингээж бүртгээгүй зэрэг зөрчил нийтлэг байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Тухайлбал,

ЭМЯ-наас хуваарилсан тоног төхөөрөмж:

- Архангай аймагт 7.4 сая, Говьсүмбэр аймагт 10.2 сая, Завхан аймагт 7.5 сая, нийт 25.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй,
- Дорноговь аймагт 195.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй,
- Завхан аймагт 32.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй,

БСШУСЯ-наас хуваарилсан тоног төхөөрөмж:

- Баян-Өлгий аймагт 7.8 сая, Дархан-Уул аймагт 4.8 сая, Өвөрхангай аймагт 26.9 сая, Увс аймагт 16.1 сая, нийт 55.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй,
- Говьсүмбэр аймагт 7.8 сая, Дархан-Уул аймагт 8.7 сая, Дорноговь аймагт 376.1 сая, Дундговь аймагт 177.6 сая, Орхон аймагт 9.2 сая, Өвөрхангай аймагт 41.3 сая, Увс аймагт 3.9 сая, нийт 624.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглалтгүй,
- Баян-Өлгий аймагт 108.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хуваарьт газарт олгоогүй,
- Говьсүмбэр аймагт 3.7 сая, Увс аймагт 3.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй,

БХБЯ-наас хуваарилсан тоног төхөөрөмж:

- АХБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн “Өмнөговь, Дорноговь амйгуудын хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил” төслийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжүүлсэн 167.0 сая төгрөгийн хог шахагч тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй,

ХНХЯ-наас хуваарилсан тоног төхөөрөмж:

- Тоног төхөөрөмжийг суурилуулах, тээвэрлэхтэй холбогдон гарсан 44.7 сая төгрөгийг өртөгт шингээж бүртгээгүй,
- Орхон аймагт нийлүүлэгдсэн 5.0 сая төгрөгийн 3 ширхэг принтер, хувилагчийн хорны олдоц муутайгаас ашиглалт хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөө хангалтгүй байна

2.26 Байнгын ашиглалтад хүлээн аваагүй барилгад үйл ажиллагаа явуулж байгаа Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6²⁹ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал,

- Хэнтий аймгийн Баян-Адрага суманд 2010-2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Өү-Ту-Юу” ХХК барьж гүйцэтгэсэн “Монгол хатдын өргөө” цогцолбор барилга, “Монгол ээж” музейн барилгыг байнгын ашиглалтад хүлээн аваагүй байхад аймгийн ИТХ-ын 2013 оны 67 дугаар тогтоолоор “Монгол хатдын өргөө цогцолборын ашиглалтын өмнөх захиргаа” нэрээр хуулийн этгээдийн бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Уг барилга, музей нь Баян-Адрага сумын ЗДТГ-ын данс бүртгэлд дуусаагүй барилгаар бүртгэлтэй байна.
- Дархан-Уул аймгийн ШУТИС-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлээс лифтний ажил хийгдээгүйн улмаас улсын комисс хүлээн аваагүй байхад 2016 оны 4 дүгээр сараас эхлэн ашиглагч байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

2.27 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2³⁰-т заасны дагуу төсвийн төсөлд санал өгөхдөө хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцооллыг гаргаж төсөвт нөлөөлөх нөлөөллийг харгалздаггүйгээс ашиглалтад орсон ч зардал, орон тооны асуудал шийдэгдэх хүртэл ашиглалтгүй байж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, тооцоолоогүй нэмэлт зардал гаргах, ашиглалтад сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, ТЭЗ-д доорх ашиглалтад орсон барилга, байгууламжийн урсгал зардлыг 2017 оны төсөвт бүрэн тусгаагүй байна.

- Шадар сайдын багцад Архангай аймгийн Цэцэрлэг, Сэлэнгэ аймгийн Мандал сумдын аврах, гал унтраах ангийн,
- ЭМС-ын багцад Завхан аймгийн Асгат сумын 10 ортой эмнэлэг, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төв, Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төв, Өвөрхангай аймгийн Бүрд сумын 10 ортой эмнэлэг, Сүхбаатар аймгийн Онгон сумын 20 ортой эмнэлэг, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын 10 ортой эмнэлэг, Төв аймгийн Борнуур сумын 10 ортой эмнэлэг,
- БСШУСС-ын багцад Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын 100 ортой дотуур байр, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 100 ортой дотуур байр, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын соёл амралтын хүрээлэн, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын усан бассейн, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 240 суудалтай сургууль, Увс аймгийн Тариалан сумын 640 суудалтай

²⁹ Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

³⁰ Хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлтийг гаргасан байна.

сургууль, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 560 суудалтай сургууль, Завхан аймгийн Улиастай сумын 320 суудалтай 3 дугаар сургууль, Ховд аймгийн Жаргалант сумын 100 ортой цэцэрлэгийн урсгал зардлыг тусгаагүй байна.

2.28 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн боловч ашиглалтгүй, ажлын чанар хангалтгүй барилга байгууламж байгаа нь уг төслийг хэрэгжүүлэх шаардлага бодитоор оршин байсан эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал,

- Сэлэнгэ аймгийн Мандал суманд баригдаж 2016 оны 12 сард ашиглалтад орсон 100 ортой дотуур байрны барилгыг 2017 оны 4 дүгээр сарын байдлаар ашиглаагүй барилгын сантехникийн хоолой задарч ус алдсанаас хана таазыг засварлах шаардлагатай, гадна хашаа, зам талбайн тохижилтийн ажил дутуу хийгдсэн, халаалтын зардлыг гүйцэтгэгч байгууллага төлж байна. (Зурагт үзүүлэв)



- Сэлэнгэ аймгийн Мандал суманд Монгол Дайвин ХХК гүйцэтгэж 2016 оны 11 дүгээр сард ашиглалтад орсон 560 суудалтай сургуулийн барилга ашиглалтгүй, 2 дугаар давхрын коридорын цонх унаж хагарсан, цантсан, дулааны алдагдал ихтэй барилгыг 2017 оны 4 дүгээр сарын байдлаар ашиглаж эхлээгүй,
- Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар багийн 878.6 сая төгрөгийн өртөгтэй Спорт заалны барилгын ажлыг 2015 онд улсын комисст хүлээлгэн өгсөн боловч ашиглалтын зардал шийдэгдээгүйгээс одоог хүртэл ашиглалтгүй байна.

2.29 ТЭЗ-дийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэл хангалтгүйгээс хэт олон барилгын ажлыг дотоодын барилгын компаниудын хүчин чадлаас давуулан төлөвлөж эхлүүлсэн, хэрэгжих хугацаанд санхүүжилтийг оновчтой хуваарилаагүйгээс 2016 төсвийн тухай хуулиар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр батлагдаагүй орхигдсон, барилга угсралтын явцад норм, стандарт зөрчигдсөн нийт 160.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 64.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон 48 барилга, байгууламж зогсонги байдалтай байгаа нь үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 5-аас харна уу)

2.30 ЭХЯ-ны төлөвлөлтийн алдаа, төслийг хэрэгжүүлэх үе шатны дараалал алдагдсан, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, газрын маргаантай, эх үүсвэрт холбогдоогүй зэргээс шинээр баригдсан дэд станц, шугам сүлжээг холбох боломжгүй, төлөвлөсөн хорооллууд ашиглалтад ороогүй, хүрэлцээтэй хэрэглэгч байхгүй зэргээс нийт 89.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 барилга, байгууламжийг ашиглах боломжгүй байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 6-аас харна уу)

2.31 Төсвийн ачааллаас хэтэрсэн олон барилгыг нэг дор эхлүүлснээс санхүүжилт хугацаандаа олгогдоогүй, гүйцэтгэгч олон тендерт зэрэг оролцож гэрээ байгуулснаас гэрээт ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүй, барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрмийг зөрчсөн гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй зэргээс ашиглах боломжгүй чанаргүй, барилгын хийц элэгдэлд орж, ашиглалтын шаардлага хангахгүй болж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

2.32 2012-2016 онуудад баригдсан цэцэрлэг, сургуулийн барилгын өртөгт хийсэн судалгаагаар хүчин чадлаас шалтгаалан янз бүрийн өртөгөөр баригдаж байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 10-т үзүүлэв)

Хүснэгт 10. 2012-2016 онд баригдсан барилгын дундаж өртөг (сая төгрөг, бүсээр)


Ангилал	Өртөг			Дундаж өртөг
	Баруун бүс	Төвийн бүс	Зүүн бүс	
Цэцэрлэгийн барилга, 100 ортой	936.8	860.7	776.0	857.8

Сургуулийн барилга, 320 суудалтай	2,016.0	2,657.1	2,008.6	2,227.2
Сургуулийн барилга, 640 суудалтай	4,106.4	3,677.3	3,021.2	3,601.6
Сургуулийн барилга, 960 суудалтай	5,540.6	3,440.0	4,461.0	4,480.5

Эх сурвалж: Барилгын хөгжлийн төв, 2016 он

2.33 Орхигдсон болон ашиглалтгүй байгаа барилгуудад олгосон нийт санхүүжилтаар алдагдсан боломжийг нийгэмд хамгийн хэрэгцээтэй байгаа сургууль, цэцэрлэгийн барилгын өртгөөр тооцож үзвэл 100 ортой цэцэрлэг 170, 320 суудалтай сургуулийн барилга 69, 640 суудалтай сургуулийн барилга 42, 960 суудалтай 34 сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулах боломж, нөөцийг алдсан байна.

2.34 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалтгүй байна. Аудитын явцад авсан санал асуулгын дүнгээс үзэхэд:



“Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг үр нөлөөтэй, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдсэн үү?” гэсэн санал, асуулгад оролцогсдын 4 хувь “үгүй” гэж хариулсан бол эрх зүйн орчин бүрдсэн боловч түүнийгээ дагаж мөрддөггүй гэж 33 хувь, харин төсвийн хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн эрх зүйн орчныг сайжруулах, шинэчлэл хийх шаардлагатай гэсэн хариулт хамгийн өндөр буюу 63 хувийг эзэлж байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинд үүрэг хариуцлага, арга хандлага дутагдаж байгааг харуулж байна.

Сангийн яам 2016 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан байна

2.35 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд 2010-2014 онуудад хийсэн аудитаар жил бүр төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн “хангалтгүй” гэж үнэлэгдсэн бөгөөд нийт 23 зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд, Сангийн сайд, ТЭЗ нарт хүргүүлсэн байна. Гурваас дээш удаа хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй зөвлөмжийг агуулгаар нь үзүүлбэл,

- Хөрөнгө оруулалтын дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах,
- Төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, нэгдсэн арга зүй удирдамжаар хангах, хуулийн шаардлага хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх,
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулсан, худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох,
- Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах зэрэг болно.

2.36 Улсын төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өмнө онуудын аудитаар илэрсэн зөрчлүүд хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд оршиж, арилахгүй давтагдаж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад УИХ-ын анхаарлыг хандуулахыг зорьсон.

2.37 2015 оны аудитаар Монгол Улсын Засгийн газарт 2 зөвлөмж өгснөөс хэрэгжиж эхэлсэн боловч бүрэн хэмжээний үр дүнд хараахан хүрээгүй байна. Тухайлбал,

2.37.1 “ТАХ-г төлөвлөхдөө тухайн төсвийн жилд ашиглалтад орох боломжтой, шилжих хөрөнгө оруулалтад санхүү, хөрөнгийн нөөцийг түлхүү хуваарилах замаар хэрэгжилтийг хангуулах” зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр:

- Сангийн яамнаас УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу 2017 оноос эхлэн шинээр хөрөнгө оруулалтын төсөл эхлүүлэхгүй байх, өмнөх жилүүдэд эхэлсэн боловч дуусаагүй ажлуудыг гүйцээн дуусгах бодлого барин төлөвлөлтийг хийх зэргээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч тайлангийн 5 дугаар хавсралтад тусгагдсан дутуу орхигдсон нийт 48 төслөөс 2017 оны Төсвийн тухай хуульд 9 ТАХ-ний санхүүжилтэд 6.1 тэрбум төгрөг батлагдсан байна.

2.37.2 “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ бүрийг төлөвлөлтийн шатнаас ашиглалтад шилжих хүртэлх хугацаанд хуулийн тусгай кодтой болгож, бүртгэлжүүлэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, дамжуулах иж

бүрэн мэдээллийн сан, цахим орчин бүрдүүлэх талаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” чиглэлээр:

- “Япон Улсын Ядуурлыг бууруулах сан”-гийн “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал”-д хийсэн судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын зорилгоор нэгдсэн, стандартчилагдсан мэдээлэл холбооны технологийн систем байхгүй, ашиглагдаж буй системүүд тус тусдаа хөгжүүлэгдэх боломжтой, нэгдсэн байдлаар ажилладаггүй, хоорондоо мэдээлэл солилцох боломжгүй, үйлдлүүд нь давтагдсан, мөн системүүдийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдээгүй зэрэг төлөвлөлтийн алдаатай байдлаас системүүд ашиглагдаагүй байна.
- Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн мэдээллийг багтаасан хяналтын иж бүрэн систем шаардлагатай хэвээр байна.

2.38 ТЭЗ-дын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүйгээс аудитаар жил бүр материаллаг дүнтэй, зөрчилтэй асуудлууд илэрч байгаа боловч засч, залруулах тал дээр төдийлөн ахиц гарахгүй байгаа нь дотоод хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Бүлэг 3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хангалтгүй, хэрэгжилтэд тавих хяналт сүл байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оны гүйцэтгэлээс 3.4 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна

Хүснэгт 11. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл (сая төгрөг)


3.1 Орон нутгийн төсвөөр шинэ 1592 арга хэмжээг 150.0 тэрбум төгрөгөөр, шилжих 647 арга хэмжээг 151.9 тэрбум төгрөгөөр буюу нийт 738.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2239 төслийг 301.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Хөрөнгө оруулалтын ТАХ-нд 264.0 тэрбум төгрөг буюу 87.5 хувийн санхүүжилт олгосон нь өмнөх онтой харьцуулахад 3,436.9 сая төгрөгөөр өссөн байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 11-т харуулае)

Аймаг, нийслэл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хувь
	ТАХ-ний тоо	Санхүүжих	ТАХ-ний тоо	Санхүүжүүлсэн	
Архангай	6	278.2	6	271.5	97.6
Баян-Өлгий	26	830.2	26	826.2	99.5
Баянхонгор	27	544.2	27	538.5	99.0
Булган	9	860	7	824.2	95.8
Говь-Алтай	25	970.1	25	883.3	91.0
Говьсүмбэр	5	146.2	5	144.2	98.6
Дархан-Уул	62	2,563.7	62	1,546.3	60.3
Дорноговь	98	2,755.1	83	1,942.6	70.5
Дорнод	52	1,397.2	39	1,212.1	86.8
Дундговь	20	626.3	18	566.7	90.5
Завхан	8	193.2	8	193.2	100.0
Орхон	326	23,823.3	287	22,672.3	95.2
Өмнөговь	90	21,571.7	90	19,166.3	88.8
Өвөрхангай	11	1,219.9	11	1,150.2	94.3
Сүхбаатар	9	1,085.9	8	712.4	65.6
Сэлэнгэ	37	1,054.3	22	734.5	69.7
Төв	73	3,241.4	68	3,107.1	95.9
Увс	24	794.9	24	748.8	94.2
Ховд	26	448.7	25	348.1	77.6
Хөвсгөл	33	918.2	27	639.8	69.7
Хэнтий	21	947.4	20	947.4	100.0
Улаанбаатар	1251	235,670.4	1175	204,891.7	86.9
Нийт дүн	2239	301,940.7	2063	264,067.2	87.5

Эх сурвалж: АНАГ-аас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийсэн аудитын тайлан

3.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтын 77.6 хувь нийслэлийн, 22.3 хувь аймгийн төсвөөс санхүүжсэн бөгөөд ТАХ-ний төрлийн хувьд дараах бүтэцтэй байна.

Дүрслэл 4. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн бүтэц (тэрбум төгрөг, хувь)



Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна

3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төлөвлөлтийн явцад зарим аймгууд эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй, ИТХ-аар шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- **Дорнод:** Бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй 283.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулсан байна.
- **Дундговь:** Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 639.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 637.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ нь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй.
- **Хөвсгөл:** Замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн 4 ТАХ нь аймгийн 2012-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, аймгийн 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, байгаль орчны мастер төлөвлөгөө зэрэг баримт, бичигт тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдаагүй байна.

3.4 Баталгаажсан зураг, төсөвгүй, газар, техникийн нөхцөл олгогдоогүй ажлыг аймгийн ИТХ-аар батлуулж Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³¹ дэх заалтыг зөрчиж байгаа нь төлөвлөлт үндэслэлгүй хийгдэх, худалдан авах ажиллагаа удаашрах, ТАХ гэрээнд заасан хугацаанд ашиглалтад орохгүй байх, ажил чанаргүй гүйцэтгэгдэх, төсөвт өртөг нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

- Дорнод аймагт 537.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16,
- Дорноговь аймагт 217.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9,
- Орхон аймагт 359.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6,
- Төв аймагт 1,456.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19,
- Увс аймагт Авто замын сангийн эх үүсвэрээр хийгдэх 8,
- Сүхбаатар аймагт 567.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5,
- Хөвсгөл аймагт 330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4,
- Хэнтий аймагт 55.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг тус тус баталгаажсан зураг, төсөвгүйгээр,
- Завхан аймагт 55.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй техникийн нөхцөл олгогдоогүй 1 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулсан байна.

Худалдан авалтад харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг түлхүү хэрэглэж ирснээр төсвийн хэмнэлт бага гарч байна

3.5 Орон нутагт төсвийн тухай хууль батлагдсан даруйд худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангаагүйгээс хэрэгжилтийг зохион байгуулахад хугацаа алдаж улирлын чанартай ажлыг оны эхний хагаст багтаан эхлүүлэх боломж бүрдээгүй байна. Тухайлбал,

- Дархан-Уул аймагт хэрэгжих 29 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2016 оны сүүлийн хагаст зохион байгуулсан,
- Төв аймгийн Зуунмод сумын 6 дугаар багийн гэр хорооллын айл өрхийн дулаан, цэвэр, бохир усны шугамын холболтын 325.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2016 оны 9 дүгээр сард байгуулсан,
- Төв аймагт нийтийн дуудлага худалдаагаар зарагдсан шинэ суурьшлын бүсийн 835.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дэд бүтцийн ажлын үнэлгээний хороог 5 дугаар сарын 30-нд байгуулж, тендерийн урилгыг 7 дугаар сарын 6-нд нийтэлсэн зэргээр хугацаа алдсанаас гэрээний хугацаанд хэрэгжих боломжгүй болж гэрээний хугацааг сунгасан байна.

3.6 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 150.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1602 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас нээлттэй тендер шалгаруулалтаар 201, хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 13, харьцуулалтын аргаар 935, шууд гэрээ байгуулах аргаар 443 ажлын гүйцэтгэгчийг шалгаруулж, 10 төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

³¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Хүснэгт 12. Худалдан авалтын хэмнэлт гараагүй ТАХ-нүүд (тоо, тэрбум төгрөг)

3.7 Хөрөнгө оруулалтын төслүүдэд төсөвлөгдсөн зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зорилгоор харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэсэн гэх боловч нийт 28.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 433 ТАХ-нээс хэмнэлт гараагүй байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 12-оор харуулав)

Ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
Зам гүүр	82	10.7
Хот тохижилтын ажил	75	5.1
Инженерийн шугам сүлжээ	32	3.0
Барилга засвар	59	4.0
Төхөөрөмж, тавилга, автомашин	120	3.8
Байгал хамгаалал	12	0.8
Зөвлөх үйлчилгээ	32	0.4
Бусад	21	0.7
Дүн	433	28.5

3.8 Аудитаар хийсэн судалгаанаас үзэхэд нээлттэй тендер шалгаруулалтад 37-256, хязгаарлагдмал тендер шалгаруулалтад 19-34 хоногийг тус тус худалдан авалтад зарцуулсан байна.

3.9 Сангийн яам орон нутгийн ТЕЗ-дын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 2016 онд 62.8 оноогоор “хангалттай” гэж үнэлсэн байна.

3.10 Гүйцэтгэгчийг сонгохдоо өрсөлдөөнийг хязгаарлах, худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгох³², шууд гэрээ байгуулах зорилгоор ажлын төсөвт өртгийг олон жижиг багцад хуваах³³ тендерийн ерөнхий шаардлагад нийцээгүй гүйцэтгэгчийг шалгаруулсан зэргээр сонгон шалгаруулалтын журмыг зөрчсөн байна. Тухайлбал,

- **Булган:** Булган сумын дээд 4-н замын уулзварт гэрлэн дохио угсарч суурилуулах ТАХ-г 22.0 сая төгрөгөөр “Сүлжээт зам” ХХК-тай шууд гэрээ байгуулах аргаар,
- **Дорноговь:** Замын-Үүд суманд хэрэгжүүлэх Газар тариалан эрхлэгчдийг дэмжих 16.6 сая төгрөгийн төсөв бүхий ажлын гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар,
- **Төв:** Зуун мод сумын 6 дугаар багийн айл өрхийн дулаан, цэвэр бохир усны шугам, 20-н айлын орон сууцны дулааны шугам, Утгаал сумд 50 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга худалдан авах зэрэг нийт 335.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар,
- **Завхан:** Цэцэн-Уул, Яруу, Улиастай сумдын модон гүүрийн засварын ажлуудыг гүйцэтгүүлэхээр зам гүүрийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй “Дээдсийн цагаан гэр” ХХК-тай тус бүр нь 8.0-9.9 сая төгрөгийн буюу нийт 27.8 сая төгрөгийн дүнтэй ажлыг шууд гэрээ байгуулах аргаар,
- **Увс:** Аймаг болон Зүүнхангай сумын ЗДТГ-т орон сууц худалдан авах 130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний худалдан авалтыг шууд гэрээ байгуулах аргаар тус тус гүйцэтгэсэн байна.
- **Орхон:** Аймгийн Цагдаагийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах ажилд 30.0 сая төгрөг 2016 онд батлагдсан ч уг байгууллага 85.0 сая төгрөгийн автомашиныг худалдан авч үлдэгдэл санхүүжилт болох 55.0 сая төгрөгийг 2017 оны ОНТ-ын хөрөнгө оруулалтаар батлуулсан ба худалдан авах ажиллагааг тухайн оны төлөвлөгөөнд тусгагдсанаар харьцуулалтын аргаар,
- **Дархан-Уул:** “Толбот хайрхан” ХХК нийтийн орон сууцны байрны инженерийн шугам сүлжээний 23.7 сая төгрөгийн засварын ажлыг 4 багцаар, “Дархан-АЗЗА” ХХК-тай, Дархан сум доторхи сайжруулсан шороон замын засвар үйлчилгээний 50.0 сая төгрөгийн ажлыг 10 багцаар, аймгийн ЗДТГ-ын байрны коридор, өрөө тасалгааны засварын 61.0 сая төгрөгийн ажлыг 4 багцаар 2 гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах аргаар,
- **Дундговь:** Нээлттэй тендер зарлахаар батлагдсан аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин худалдан авах 140.0 сая төгрөгийн ТАХ-г 4 багц болгон хувааж 70 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 автомашиныг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, бусад 3 автомашиныг харьцуулалтын аргаар,

³² ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.7.1 дэх заалт тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох

³³ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2 дахь заалт “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.”

- **Өвөрхангай:** Нийт 377.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г 4 гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах аргаар, засварын 73.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-г багцуудад хуваан 10 иргэнтэй шууд гэрээ байгуулах аргаар,
- **Төв:** Аймгийн ЗДТГ-ын 217.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, тохижилтийн ажлыг 3 багцад хувааж, харьцуулалтын аргаар,
- **Орхон:** “Сэхүүн чоно” ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогц барилга угсралтын ажилд нэгдсэн нэг төсөв хийгдээгүй, 2014 оноос тухайн жилд хийгдэх ажилд хэсэгчилсэн төсөв хийх байдлаар уг ТАХ-ыг хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13.6 хувийг улсын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихэд зарцуулсан байна

3.11 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³⁴ дэх заалтад нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 13-т харуулав)

Хүснэгт 13. Улсын төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын санхүүжүүлт (сая төгрөг)

Ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжсэн дүн
Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө оруулалт болон урсгал зардалд нийт	613	50,173.2	39,466.3	35,978.1
1. Улсын төсвийн орон нутгийн өмчит байгууллагад хийсэн хөрөнгө оруулалт	451	42,830.6	32,564.8	29,790.5
2. Улсын төсвийн, төрийн өмчит байгууллагад хийсэн хөрөнгө оруулалт	151	7,342.5	6,901.5	6,187.6
3. Орон нутгийн төсвийн байгууллагын урсгал зардалд	11	760.4	705.4	679.3
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хамаарахгүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн хувь		6.8	13.1	13.6

Эх сурвалж: Судалгааны дүн

3.12 Улсын төсөвт байгууллагын урсгал зардал болон барилга байгууламж барих, хөрөнгө шинээр бэлтгэх, засварлах, ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх чиглэлээр 602 ТАХ-г 36.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 13.6 хувьтай тэнцэж байгаа төдийгүй өнгөрсөн онтой харьцуулахад ТАХ-ний тоо 440, санхүүжүүлэх дүн 23.1 тэрбум төгрөгөөр буюу 2.8 дахин өсчээ.

3.13 ИТХ-аар батлагдан төсөвт тусгагдсан ТАХ-ний санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³⁵ дах заалттай нийцэхгүй байна. Үүнд:

Орхон:

- Цагдаагийн газарт орон нутгийн 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтаар техник тоног төхөөрөмж худалдан авах 30.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 85.0 сая төгрөгөөр land cruiser 200 маркийн авто машин худалдан авч зөрүүг 2017 онд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр баталсан,
- ОБГ-т орон нутгийн 2016 оны төсвийн хөрөнгө оруулалтаар аврах эрэн хайх ажиллагааны механизм, тусгай техник тоног төхөөрөмж худалдан авахад 45.0 сая төгрөг батлагдсан боловч авто машин худалдан авсан,
- Хүүхэд залуучуудын театрт тоног төхөөрөмж нийлүүлэх 25.0 сая төгрөг батлагдсан боловч Старекс маркийн автомашин худалдан авсан.

Өмнөговь:

- Урсгал зардлын 884.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байна.

3.14 Хувийн компаниудын худалдан борлуулах зорилгоор барьсан орон сууцны дулааны эх үүсвэр, гадна дулааны сүлжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, дулааны эрчим хүчээр хангах үүргийг ОНӨААТҮГ-т хариуцуулж байгаа нь цаашид тухайн

³⁴ “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжиж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

³⁵ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”

байгууллагын үр ашгийг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна. Тухайлбал,

Булган:

- “Дэлгэрэх-Өргөө” ХХК-ийн барьсан 27 айлын орон сууцны барилгад аймгийн төсвөөс 40.0 сая төгрөгөөр халаалтын зуух, гадна шугам сүлжээг хийх эх үүсвэрийг шийдвэрлэж, орон сууцны халаалтын үйлчилгээ үзүүлэх үүргийг ОНӨААН-д хариуцуулсан байна.

3.15 Хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагаа урьдчилан судалж, хэрэгжих боломжтой эсэхийг тооцож төлөвлөөгүй, шаардлага хангаагүй төхөөрөмж хэрэгсэл нийлүүлэгдсэн, ТАХ-г чанаргүй хийж гүйцэтгэсэн зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулалт үр ашиггүй, үр өгөөж багатай болсон байна. Тухайлбал,

Дархан-Уул:

- Ерөнхий боловсролын 11 сургуульд 72.8 сая төгрөгөөр “Шилэн сургууль” цахим системийг нэвтрүүлсэн ч судалгаагаар багш, эцэг эхийн хоорондын цахим харилцаа цөөхөн байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө хэрэглэгчийн нөхцөл байдалд судалгаа хийж, ашиглах цаг хугацааг харгалзаагүйтэй холбоотой,

Дорноговь:

- Сүүлийн 3 жилийн байдлаар Сайншанд сумын 1, 2, 3 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр бохир усны шугамд холбох ажлын гүйцэтгэлд нийт 225.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2013-2017 онуудад 39 өрх цэвэр усны шугамд, 7 айл өрх бохир усны шугамд холбогдсон,
- Сайншанд сумын Соёмбо цогцолборт 9.9 сая төгрөгөөр 5D кинотеатрын дотор хана угсрах, дуу тусгаарлалт хийх ажлыг 2016 оны 6 сард дуусгаснаас хойш зориулалтын дагуу ашиглаагүй, уг өрөөнд аймгийн Ахмадын хороо үйл ажиллагаагаа явуулсан,

Орхон:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн орон сууцны хорооллын 237 орцонд соронзон кодтой хаалга суурилуулах 496.4 сая төгрөгийн төсөвтэй ТАХ хэрэгжсэн ч эзэмшигч тодорхойгүйгээс эзэнгүйдэж, тоногдсон нь үр дүнгүй хөрөнгө оруулалт болох үр дагавартай,

Сэлэнгэ:

- Шаамар сумын Ахмадын өргөөнд халаалт тавих ажлыг гүйцэтгүүлэхээр “Поли эрчим” ХХК-тай 6.0 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан, 7 ширхэг цахилгааны эх үүсвэр бүхий халаалт тавьсан боловч ашиглалтын зардал өндөр гардаг гэдэг шалтгаанаар ашиглагдаагүй,
- Жавахлант сумын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах, гал тогоо, цахилгааны засварын ажилд 15.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий чанарын шаардлага хангахгүй тогоо нийлүүлсэн,
- Ахмад залуу гэр бүлийн ёслолын ордны үндсэн барилга ашиглалтад ороогүйн улмаас 2016 онд ашиглалтад хүлээн авсан 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэр бүлийн ёслолын өргөө (монгол гэр) нь өнөөг хүртэл ашиглагдахгүй, цас, бороонд норж, тоос шороо дарсан, өнгө үзэмж муудсан байдалтай байна.

Увс:

- Сумын төрийн байгууллагын ажилтнуудыг аймагт ажлаар очих үед нь байрлуулах зорилгоор Зүүнхангай сумын ЗДТГ-т 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, аймгийн ЗДТГ-т орон нутагт ажиллах босоо тогтолцоотой байгууллагуудын дарга нарт түрээсээр ашиглуулах зорилгоор 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 дахь орон сууцыг тус тус худалдан авсан байна.

Өвөрхангай:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Арвайхээр сумын хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлыг зөөвөрлөх зорилгоор хог тээврийн 2 авто машиныг нийт 58.0 сая төгрөгөөр буюу зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан ба уг KIA TRADE маркийн авто машин 1996 онд үйлдвэрлэгдсэн нь техник ашиглалтын шаардлага хангахгүй байна.
- Арвайхээр сумын төв зам дагуух гэрэлтүүлгийг шинэчлэхдээ толгой болон Led гэрлийг 30.1 сая төгрөгт багтаан сольж гэрэлтүүлгийг сайжруулах боломжтой байхад 79.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гэрэлтүүлгийн шон болон бусад хэсгийг бүрэн солихоор төсөвт тусгаж хэрэгжүүлсэн ч чанарын шаардлага хангахгүй байна. “УТООБ” ХХК нь 119.6 сая төгрөгийн 2 ТАХ-г гүйцэтгэснээс “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” цогцолборын барилгын тоног төхөөрөмжийг 85.3 сая төгрөгөөр нийлүүлэхдээ бүрэн бүтэн байдал, туршилт тохируулга хийж хүлээлгэн өгөөгүйгээс хөрөнгө ашиглалтгүй байна.

Өмнөговь:

- Мандал-Овоо, Баяндалай сумдад 120.2 сая төгрөгийн өртөгөөр “Хайрхан бар” ХХК-ийн нийлүүлсэн уурын зуухны тогоо ашиглах явцад эвдрэл үүссэнээс цаашид ашиглах боломжгүй болжээ.

- Ахмадын хээрийн сувилалд 19.0 сая төгрөгийн өртөгөөр гаргасан гүний худаг усны ундарга багатайгаас ашиглалтгүй байна.
- Даланзадгад суманд баригдсан 92.8 сая төгрөгийн өртөгтэй хог хаягдлын цэгийн барилгын ажлыг 2016 оны 6 дугаар сарын 24-нд улсын комисс хүлээн авч гүйцэтгэгчээр дутуу хийгдсэн ажлуудыг дуусгах үүрэг өгсөн ч “Кайши” ХХК 2017 оны 3 дугаар сарын байдлаар ямар ч ажил хийгээгүйгээс ашиглах боломжгүй байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хариуцлагагүй байдлаас өмнөх зөрчлүүд давтагдан гарч байна

3.16 Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 301.9 тэрбум төгрөгийн 2239 ТАХ-нээс 155.1 тэрбум төгрөгийн 1317 ТАХ бүрэн хэрэгжиж, 135.6 тэрбум төгрөгийн 847 ТАХ гэрээт хугацаанд дуусаагүй байгаа нь төсвийн орлого бүрдэлт хангалтгүйгээс ажлын гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлж чадаагүй, гүйцэтгэгчтэй холбоотойгоор ажил удааширсан, захиалагчийн хяналт сул байгаа, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 14-өөр харуулав)

Хүснэгт 14. ТАХ-ний хэрэгжилтийн байдал (тэрбум төгрөг)

Хэрэгжилт	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл
Ашиглалтад хүлээн авсан	1317	291.0	155.1	138.2
2017-2018 онд хэрэгжиж дуусах	75	37.4	11.2	9.2
Гэрээний хугацаанд дуусаагүй	847	410.8	135.6	116.7
Нийт	2239	739.2	301.9	264.1

Эх сурвалж: Судалгааны үр дүн

3.17 Комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн аваагүй, ажлын гүйцэтгэл дутуу, технологийн алдаатай баригдсан барилга байгууламж, ТАХ-ний гүйцэтгэлийг хуурамчаар үйлдэж санхүүжилтийг бүрэн олгосон нь хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, ашиглагч байгууллагаас нэмэгдэл зардал гарах нөхцөлийг үүсгэсэн байна. Тухайлбал,

Дорноговь:

- Хөвсгөл сумын сургуулийн хичээлийн байр, спорт заал, цайны газрын засварын 91.8 сая төгрөгийн ажлыг 2015 онд хийж гүйцэтгэсэн “Их хашаат” ХХК-д 2016 оны аудитаар барилгын дээврийн 40.6 сая төгрөгийн ажлыг дахин засварлуулах албан шаардлага өгсөн боловч гүйцэтгэгч уг ажлыг хийлгүйгээр хэрэгжсэн гэсэн албан бичиг үйлдэж санхүүжилтээ бүрэн авсан,

Завхан:

- Улиастай сумын Жинст багийн 4 замын уулзварын гэрлэн дохио суурилуулах, Жинст, Богдын гол, Жаргалант багуудын зам засвар, Жаргалант багийн Чигэстэй голын модон гүүрийг засварлах зэрэг 95.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээнүүдийг улсын комисс хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон,

Орхон:

- Баян-Өндөр суманд 1 худаг шинээр, 5 худаг сэргээн засварлах, Жаргалант суманд 1 худаг шинээр, 3 худаг сэргээн засварлах ажлыг “Хөвсгөл ундарга” ХХК 68.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээс 14.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр гаргах 1 худгийг гаргаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон,

Төв:

- Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 312.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 13 зам засварын ажлаас 11 ажлыг комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хэнтий:

- “Үвгэн баавай” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Гурванбаян тосгоны Дунд баяны 10 тоннын даацтай гүүрийн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг улсын комисс хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
 Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.06.06 № 9/34Н
 танай 2017.06.05-ны № 1045 -Т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
 АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 С.ОЮУНБИЛЭГ ТАНАА**

“Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасны дагуу санал боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Эдгээр саналуудыг тайланд тусган дэмжиж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГА





Б.НЯМАА

2192



Сангийн яамны 2017 оны 06-р сарын 06-ны өдрийн ...9/3411... тоот бичгийн хавсралт

“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ

Бүлэг 1.

Тайлбар 1. Улсын хөрөнгө оруулалтын 2013-2017 оны хөтөлбөрт 2016 онд хэрэгжүүлэхээр тусгасан төслийн талаар бичигдсэн тул тайлангаас хасах шаардлагагүй

Тайлбар 2. Саналыг хүлээн авч тухайн хэсэгт найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 3. Зарим саналыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийв.

Тайлангийн төсөл /цаашид “тайлан” гэх/-ийн 1.3 заалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чойр-Сайншандын 220 кВ-ын хэлхээт 230 км ЦДАШ, Сайншандын 220 кВ-ын дэд станцыг барих ажил хэрэгжих ёстой байсан ч хөрөнгийн дутагдлаас шалтгаалан хэрэгжих боломжгүй болсон гэжээ. 2016 онд уг ажилтай холбоотой ямар нэгэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт УИХ-аас батлагдаагүй тул уг хэсгээс хасах;

Тайлангийн 1.12 заалт

ЗТХС, ЭХС-ын багцад төсвийн төслөөс гадуур нэмж батлагдсан гэх 4 ажил нь 2016 оны Төсвийн тухай хуулийн төсөл УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байх үед зарчмын зөрүүтэй саналын дагуу нэмэгдсэн ажлууд бөгөөд Улсын төсөв, Хөгжлийн банкны холбогдох төсөл, арга хэмжээний жагсаалт дотор батлагдсан тул “төсвийн төслөөс гадуур нэмж батлагдсан” гэснийг “Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдэж батлагдсан” гэж өөрчлөх, үүнтэй холбоотойгоор тайлангийн 1.20-д заасан уг 2 сайдын багцын ажлуудыг хасах;

Тайлангийн 1.19 заалт

Нэр байршил, хэрэгжих хугацаа зөрүүтэй төсөл, арга хэмжээний жагсаалтад туссан Замын-Үүдийн хилийн боомтын 11 км зам 48000 м² талбайн өргөтгөл төсөл, арга хэмжээ нь авто замын ажил тул Гаалийн ерөнхий газрын багцад бус ЗТХС багцад батлагдаж, эрх шилжүүлэх замаар хэрэгжүүлэхээр тусгасан ажил тул уг хэсгээс хасах; мөн хэсэгт тусгагдсан Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5 км /Ховд, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээ нь 2014-2016 онд хэрэгжиж тухайн онуудад санхүүжиж дууссан ба тайлангийн төсөлд туссан Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, 4.312 км /Ховд, Жаргалант/ төсөл, арга хэмжээ нь дээрх төсөл, арга хэмжээнээс тусдаа, 2016 оноос шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ тул тухайн хэсгээс хасах, түүнчлэн Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ Засгийн газрын 2015 оны 313 тоот тогтоолын хүрээнд хийгдэх авто зам, **гудамж төсөл** /Төв, Хөшигийн хөндий/ төсөл, арга хэмжээний хүрээнд ЗТХС-ын тушаалаар уг Сүхбаатар аймгийн төвийн 2 авто замын төслийг хэрэгжүүлэхээр баталсан байсан боловч төсөл, арга хэмжээний нэрийг 2017 оны Төсвийн тухай хуулиар өөрчилж, “гудамж төсөл” гэснийг хасч тухай хугацаанд уг 2 ажлын санхүүжилтийг олгоогүй байгаа тул уг хэсгээс хасах;

Тайлбар 4. Холбогдох хуульд заасны дагуу хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх үүрэгтэй тул саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлангийн 1.20 заалт

Зураг төсөл, бэлэн болоогүй гэсэн заалтад туссан БСШУСС болон ЭМС-ын багцад дурдагдсан их засварын ажлууд нь багц дүнгээр батлагддаг бөгөөд тухайн салбарын сайдын тушаалаар задалж, тухайн дүндээ багтаан зураг төсөв хийгддэг тул холбогдох ажлуудын нэрийг хасах, мөн Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, 4.312 км /Ховд, Жаргалант/ ажил нь нэгдсэн зураг төсөвтэй байсан, Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын их засвар /Хэнтий/, ЭХС-ын багцын 2 төсөл, арга хэмжээ нь УИХ-н хэлэлцүүлгийн явцад батлагдсан тул хасах,

Монгол Улсын Шадар сайдын багцад тусгагдсан Завхан аймгийн Тэс сумын аврах ангийн барилгыг худалдан авахаар төлөвлөж 2016 оны төсвийн тухай хуульд "Аврах гал унтраах 57 дугаар ангийн барилга худалдан авах, засварлах /Завхан, Тэс сум/" гэсэн нэртэй төсөл, арга хэмжээ батлуулсан бөгөөд нийт 190.0 сая төгрөг батлагдсанаас 70.0 сая төгрөгөөр тус суманд байгаа барилгыг худалдан авч, 119.9 сая төгрөгөөр их засварын ажил хийж гүйцэтгэн барилгыг бүрэн ашиглалтад оруулсан тул тухайн хэсгээс хасах;

Тайлбар 5. Төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, тухайн онд хийгдэх ажлын төсөв магадлалаар баталгаажаагүй нь баримтаар нотлогдож байх тул саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлангийн 1.21 заалт

ЗТХС-ын багцын "Сумын доторх хатуу хучилттай авто зам, 3 км /Завхан, Тосонцэнгэл сум/ төсөл, арга хэмжээ" нь улсын төсвийн хөрөнгө оруулалт болон векселиэр санхүүжих хоёр тусдаа төсөл, арга хэмжээ байсан тул тухай хэсгээс хасах,

Батлан хамгаалах сайдын багцад 2016 онд батлагдсан Говийн бүсийн сургалтын төвийн уурын зуух, гаражиин барилгын ажлыг гүйцэтгэхдээ өмнө нь экспертизээр баталгаажуулсан барилгын зураг төсөвт үндэслэн холболтын зураг төсвийг боловсруулан ажлыг хийсэн тул уг ажлыг хасах, Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд баригдсан барилга байгууламжийн зурагт магадлангийн дүгнэлт хийгдсэн байх тул уг ажлыг тухайн хэсгээс хасах;

Тайлбар 6. Хуулийн шаардлагад нийцээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.

Тайлангийн 1.42 заалт

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журам заалтыг бүрэн мөрдөөгүй гэсэн хэсэгт байгаа Ховд болон Баян-Өлгий аймгийн төвүүдийн хатуу авто замын шинэчлэлтийн ажлуудыг Засгийн газрын шийдвэрээр шууд гэрээ байгуулахаар заасан боловч шууд гэрээ байгуулаагүй тул хасах;

Тайлангийн 1.44 заалт

Тайлбар 7. Хуулийн шаардлагад нийцээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.

Дорноговь аймгийн Зүүнбаян суманд барих кобаны барилгын байршил Ханги боомтод барихаар өөрчлөгдсөн тул хуулийн дагуу өмнөх байршилд шалгарсан өмнөх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажлыг хийсэн тул хасах; /Захиалагч өмнө нь сонгон шалгаруулсан гүйцэтгэгчийн саналаас илүү сайн санал ирэхгүй гэж тооцон шалгарсан компанитай гэрээ байгуулж ажлыг хийлгүүлсэн./

Тайлбар 8. Саналын зарим хэсгийг хүлээн авч тайланд холбогдох өөрчлөлтийг оруулав.

Тайлбар 9. Зарим ажлын талаарх зөрчлийн мэдээллийг тайлангаас хасав.

Тайлбар 10. Саналыг хүлээн авч, найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 11. Саналыг хүлээн авч зөвлөмжид өөрчлөлт оруулав.

Бүлэг 2.

Тайлангийн 2.14 заалт

Ажлын гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон төслийн жагсаалтанд тусгагдсан Баянхонгор аймгийн Баянговь сумын Соёлын төвийн барилгын ажил гэрээний дагуу 100 хувь хийгдэж санхүүжилтээ бүрэн авсан боловч анхны зураг төсөвт батлагдаагүй нэмэлт ажил байгааг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан. Нэмэлт ажлын санхүүжилтийг нэмж шийдвэрлэх хүсэлт салбарын яамнаас ирж байгаа тул уг ажлыг тухайн хэсгээс хасах;

Мөн ЭХС-ийн багцын Булган аймгийн дулааны станц, дулааны шугамын ажил нь 2016 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй, Концессын гэрээгээр хэрэгжиж байгаа мөн Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын ажилд техникийн комисс ажилласан, "ДЦС-4"-өөс "У-18" хүртэлх дулааны шугамын ажил нь 2017 онд шилжин хэрэгжиж байгаа санхүүжилт дутуу гэрээ дуусгавар болоогүй байгаа тул эдгээр ажлыг уг хэсгээс хасах;

Эрүүл мэнд, Боловсролын салбарын бусад ажлуудын хувьд салбарын яамнаас хянан баталгаажуулж ирүүлсэн санхүүжилтийн хүсэлт, материалын дагуу Сангийн яамнаас санхүүжилтийг олгосон болно.

Тайлангийн 2.15 заалт

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилгын магадлашгүй ажлаас бусад ажлуудад аудит хийгдэх үед баримт, бичгийн бүрдэл дутуу архивлагдсан байсан тул бүрдлийг хангах ажил хийгдсэн.

Тайлангийн 2.18 болон 2.19 заалт

Аймаг, дүүргийн доторх гудамж, зам, талбайн тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Ховд/ төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн АСЕМ-н авто замуудын санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 53 дугаар тогтоолын дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн тул 2.19 дэх заалтын "Сангийн яам эрх нээж санхүүжилтийг олгосон" гэдгийг "Хөгжлийн банкнаас олгосон" гэж өөрчлөх;

Засгийн газарт өгөх зөвлөмж

2 дахь зөвлөмж буюу Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал нь УИХ-ын бүрэн эрхийн асуудал бөгөөд Засгийн газраас зөвлөмжийн биелэлтийг хангахад хүндрэлтэй тул уг зөвлөмжийг хасах;

Дараах зөвлөмжүүдийг нэмж тусгах. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг батлагдсан зураг төсвийн дагуу хянаж, шалгалт хийсний үндсэн дээр гаргах, захиалагчийн техникийн хяналтыг сайжруулах, барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтанд оруулах талаар анхаарч ажиллах
- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, чанаргүй барилга байгууламж барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг цуцалж, хохирлыг барагдуулан хариуцлага тооцох.

-хОх-

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Монгол Улсын 2013-2017 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2016 онд 5 эх үүсвэрээс 13,549.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөснөөс томоохон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд эх үүсвэргүйгээс шалтгаалан хэрэгжээгүй, хөтөлбөрт төсөв санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан тодотгол хийгээгүй, хөтөлбөр үргэлжлэх бүхий л хугацаанд хэрэгжилтийг гаргаж тайлагнаагүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөлөлд хөрөнгийн зардлын хэмжээг 1,930.5 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 7.0 хувь байхаар тогтоосныг 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хөрөнгийн зардлын хэмжээг 2,350.0 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх хэмжээг 9.7 хувь байхаар буюу 2.7 хувиар нэмэгдүүлэн өөрчилсөн байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт нь Засгийн газрын 2015 оны 262 дугаар тогтоолоор батлагдсан төсвийн хөрөнгийн зардлын хязгаараас 5.5 дахин их байна. Тус хуулиар батлагдсан төслүүдийг ТЕЗ-дын төсвийн төсөлд ирүүлсэн саналтай харьцуулахад 106.8 тэрбум төгрөгийн 79 төсөл, арга хэмжээ хасагдаж, 97.1 тэрбум төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ шинээр нэмэгдсэн байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгөөр 33 арга хэмжээнд 235.4 тэрбум, Хөгжлийн банкны санхүүжилтээр 3 төсөл, арга хэмжээнд 125.7 тэрбум төгрөгийн эх үүсвэр төлөвлөснөөс Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 16 төсөл, арга хэмжээнд 137.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас харахад үндсэн чиглэлд тусгагдсан нийт арга хэмжээний 38.0 хувьд санхүүжилт төсөвлөгдсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тухайн оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хөрөнгийн зардлын хэмжээ, батлагдсан төсвийн хөрөнгийн зардлын хязгаар, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэхээр баталж байгаа зарим төсөл, арга хэмжээ хоорондын хамаарал, уялдаа холбоо хангагдаагүй, бодлогын хэрэгжилтийг хангахуйц байдлаар төлөвлөгдөөгүй нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн нэгдсэн аргачлалыг боловсруулж, төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, дарааллаар нь хэрэгжүүлж байх шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар нийт 5,063.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 816 төсөл, арга хэмжээнд 1,358.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас шилжих 750 төсөл, арга хэмжээнд 1,235.6 тэрбум төгрөг, шинээр эхлүүлэх 66 төсөл, арга хэмжээнд 123.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилагдсаныг өмнөх онтой харьцуулахад төсөл, арга хэмжээний тоо 30.1 хувиар, санхүүжих дүн 70.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ТЕЗ нар хөрөнгө оруулалтын төслүүдийг төлөвлөхдөө төсвийн хөрөнгийн зардлын хязгаараас хэд дахин нэмэгдүүлж, зураг төсөв нь баталгаажаагүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл авагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөөр байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар 2,774.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 637 төсөл, арга хэмжээг иж бүрэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөснөөс 564 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжиж, 217.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 57 арга хэмжээний хэрэгжилт дутуу, 33.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил хангалтгүй хийгдсэнээс хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны тайлангаа Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэггүй, хуульд заасан олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах шаардлагыг бүрэн хэрэгжүүлдэггүй, сонгон шалгаруулалт явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлаагүй зөрчил ТЕЗ нарын үйл ажиллагаанд давтагдан гарсан хэвээр байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2012-2015 онд хэрэгжүүлж эхэлсэн 160.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээнд өмнө нь 64.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогджээ. Гэвч эдгээр төсөл, арга хэмжээний хүрээнд баригдсан зарим барилгын норм, дүрэм, стандарт хангагдаагүй, зарим барилгын үлдэгдэл санхүүжилтийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд батлаагүйгээс эх үүсвэргүй болсон зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулалт үр ашиггүй болсон байна.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хоорондын уялдаагүй, бодлогын алдаатай байдлаас шалтгаалаад эрчим хүчний салбарт 2014-2016 онд хэрэгжүүлсэн 89.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 дэд бүтцийн барилга, байгууламжийг зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй, хөрөнгө оруулалт үр дүнгүй болсон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 2063 төсөл, арга хэмжээг 264.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байгаа нь төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуульд заасан шаардлагын дагуу төлөвлөөгүй, ТЭЗ нар захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлдэггүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцдоггүй, хуурамч гүйцэтгэл гаргадаг, захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулдаг, дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Төсвийн тухай, Барилгын тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөөгүй албан тушаалтнуудтай тооцох хариуцлагын механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зөвлөмж:

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна” гэсэн заалтад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулж, бүх төрлийн эх үүсвэрээр хэрэгжих төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг бүрэн хэмжээгээр тусгах нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжүүлэхэд дөхөмтэй байгаа тул анхаарлаа хандуулна уу.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөлтийн шатнаас ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд бүртгэлжүүлж хувийн хэргийг бүрдүүлэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, дамжуулах иж бүрэн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажлын үр дүнг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэн үр нөлөөг тооцож ажиллах;
- Хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашгийг бууруулж байгаа нөлөөллийг тогтоож, түүнийг арилгах чиглэлээр холбогдох хууль, журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох саналыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эхэлсэн боловч хуульд тусгагдаагүй орхигдсон, хэрэгжиж дууссан ч ашиглалтгүй байгаа төсөл, арга хэмжээний үр ашгийг сайжруулах талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Сангийн сайдад:

- Төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашгийг тооцох, ач холбогдлоор нь үнэлэх аргачлалыг боловсруулж, батлуулах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд илүү олгосон санхүүжилтийн судалгааг Төрийн сангаар гаргуулж, буруутай этгээдэд хариуцлага тооцох саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ авч, арга зүйгээр хангаж ажиллах;

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, дүнг тайлагнах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг техник, эдийн засгийн үндэслэл, баталгаажсан зураг, төсвийн дагуу хянах, захиалагчийн техникийн хяналтыг сайжруулж, барилга байгууламжийг хуульд заасан хугацаанд ашиглалтад оруулахад анхаарч ажиллах;
- Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, чанаргүй барилга байгууламж барьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг цуцалж, хохирлыг барагдуулан хариуцлага тооцох;
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудит хийж байх.

Хавсралт 1

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР
ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЭЗ	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжилт дутуу шалтгаан						
			Эхлэх	Дуусах			Гүйцэтгэчийн буруутай үйл ажиллагаанаас	Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас	Санхүүжилт дутуу олгогдсон	Зураг төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийгдсэн	Гадна инженерийн дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй	ХАА-г хугацаа алдаж зохион байгуулсан	Бусад
А		Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	ЭМС	2010	2016	5,597.4	1,554.3		1					
2	Эрүүл мэндийн төв /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	ЭМС	2014	2016	1,315.8	410.6					1		
3	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	ЭМС	2012	2016	12,450.9	6,314.8				1			
4	Хараагүй иргэдийн 90 айлын орон сууцны барилга /Улаанбаатар/	ХНХС	2015	2016	4,850.0	3,221.5				1			
5	Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	ХНХС	2016	2016	1,400.0	1,400.0		1					
6	Баянгол хүүхдийн зуслангийн цогцолбор /Улаанбаатар, Налайх дүүрэг/	ХНХС	2014	2016	4,300.0	1,475.0							1
7	Хүүхэд залуучуудын ордон /Говь-Алтай, Есөнбулаг сум/	ХНХС	2012	2016	2,780.0	962.7			1				
8	Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл, 2 дугаар үе шатны ажил /Улаанбаатар/	ЭХС	2015	2016	1,431.1	31.1					1		
9	Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл /Увс, Өлгий сум/	ЭХС	2016	2016	231.0	231.0		1					
10	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	ЭХС	2011	2016	7,000.0	2,000.0		1					
11	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Орон сууцны хороолол" төсөл /монголын талын хөрөнгө/ /МҮОНРТ-ийн хороололд хийгдэх холбооны худаг сувагчлалын техникийн нөхцөл авах, зураг төсөл боловсруулах, холбооны худаг сувагчлал шинээр угсрах, засварлах ажил/	БХБС	2016	2016	360.3	360.3		1					
12	Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн монголын талын хөрөнгө /Орхон, Баян-Өндөр сум/	БХБС	2013	2016	9,224.8	2,400.0	1						
13	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Тэс, Бөхмөрөн, Хяргас, Ховд, Малчин, Завхан, Баруунтуруун, Цагаанхайрхан сум/	БХБС	2014	2016	2,000.0	579.0	1						
14	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох /Архангай/	БХБС	2013	2016	3,970.0	407.9	1						

Үргэлжлэл - Хавсралт 1

15	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай замаас Өргөн сум хүртэлх 18.25 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	ЗТХС	2007	2016	2,301.2	750.0	1							
16	АСЕМ-ын чуулга уулзалтын аюулгүй байдлыг хангах Иргэний нисэхийн ерөнхий газрын тоног төхөөрөмж	ЗТХС	2016	2016	13,500.0	13,500.0							1	
17	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Говь-Алтай, Тайшир сум/	БСШУСС	2013	2016	550.0	275.0			1					
18	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 18 дугаар хороо/	БСШУСС	2012	2016	1,200.0	1,094.0	1							
19	Сургуулийн хичээлийн байр, спорт заалын барилга, 320 суудал /Архангай, Хангай сум/	БСШУСС	2014	2016	2,882.1	1,010.8	1							
20	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/	БСШУСС	2014	2016	1,400.0	1,050.0	1							
21	Сургуулийн барилга, 640 суудал, /Дорнод, Баян-Уул сум/	БСШУСС	2012	2016	3,958.7	600.0				1				
22	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Булган, Тэшиг сум/	БСШУСС	2011	2016	950.0	200.0	1							
23	Сургуулийн барилгын өргөтгөл /Говь-Алтай, Бугат сум/	БСШУСС	2012	2016	1,586.6	559.6			1					
24	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	БСШУСС	2011	2016	3,810.7	855.9								1
25	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Баянзүрх сум/	БСШУСС	2011	2016	2,710.0	731.2	1							
26	Спорт заалын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 61 дүгээр сургууль/	БСШУСС	2012	2016	1,050.0	277.5	1							
27	Сургуулийн хичээлийн байрын барилга /Дархан-Уул, Дархан сум, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургууль/	БСШУСС	2013	2016	3,006.9	1,116.0	1							
28	Сургуулийн өргөтгөлийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 6 дугаар сургууль/	БСШУСС	2012	2016	1,111.6	555.8			1					
29	Сургуулийн дотуур байрын барилга, 150 ор /Баян-Өлгий, Алтай сум/	БСШУСС	2015	2016	1,417.9	500.9			1					
30	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	БСШУСС	2012	2016	786.6	84.9	1							
31	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Булган, Булган сум, 1 дүгээр цэцэрлэг/	БСШУСС	2012	2016	1,340.2	300.2	1							
32	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 84 дүгээр сургууль/	БСШУСС	2015	2016	1,300.0	1,300.0				1				
33	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	БСШУСС	2012	2016	1,100.0	500.0		1						
34	Соёлын төвийн барилга /Хөвсгөл, Рашаант сум/	БСШУСС	2014	2016	1,500.0	656.5	1							
35	Соёл, амралтын хүрээлэн /Говь-Алтай, Есөнбулаг сум/	БСШУСС	2014	2016	2,000.0	871.4	1							
36	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	БСШУСС	2011	2016	8,353.7	1,079.2			1					
37	Соёлын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Дэнж баг/	БСШУСС	2012	2016	1,174.8	562.8	1							
38	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баянговь сум/	БСШУСС	2014	2016	950.0	81.6					1			
39	Баруун монголын уламжлалт соёлын төв /Увс, Улаангом сум/	БСШУСС	2012	2016	2,332.0	344.4								1
40	Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилга, 1080 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	БСШУСС	2008	2016	19,604.7	1,250.0	1							
41	Соёлын төв, Захирагчийн албаны барилга /Сэлэнгэ, Орхонтул сум/	БСШУСС	2012	2016	159.2	159.2			1					
42	Мал эмнэлгийн хүрээлэнгийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	БСШУСС	2013	2016	2,000.0	982.3					1			

Үргэлжлэл - Хавсралт 1

43	Биологийн идэвхтэй бэлдмэлийн үйлдвэрлэл, туршилтын цех /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	БСШУСС	2012	2016	2,042.2	771.1							1
44	Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/	БСШУСС	2013	2016	1,500.0	48.7				1			
45	Спорт заалын барилга /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	БСШУСС	2012	2016	1,420.9	589.4			1				
	Нийт дүн				145,911.3	54,006.6	17	6	8	5	4	1	4

Хавсралт 2

УЛСЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТЕЗ	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан			
			Эхлэх	Дуусах			ХАА-г зохион байгуулаагүй	ХАА хүчингүй болсон	Техникийн нөхцөл олгогдоогүй	Бусад
А		Б	1	2	3	4	5	6	7	8
1	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын зураг, төсөв /Булган/	ХНХС	2016	2016	335	335			1	
2	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын зураг, төсөв /Дорноговь/	ХНХС	2016	2016	335	335			1	
3	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, 4.5 км /Баян-Өлгий, Өлгий сум/	ЗТХС	2016	2017	2253.8	5000				1
4	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэлт, 4.312 км /Ховд, Жаргалант/	ЗТХС	2016	2017	2529.5	5000		1		
5	Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын их засвар /Хэнтий/	ЗТХС	2016	2017	7500.0	2500.0		1		
6	Их засвар, шинэчлэлийн ажлын зураг төсвийн үнийн үлдэгдэл санхүүжилт	ЗТХС	2013	2016	2202	202				1
7	Их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/	БСШУСС	2011	2017	752.9	7529		1		
8	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /1 цэцэрлэг, 21 сургууль/	БСШУСС	2016	2017	1000.0	2000				1
9	Сургуулийн барилга, спорт заал /Завхан, Цэцэн-Уул сум/	БСШУСС	2016	2017	1700.0	3000	1			
10	Хүүхдийн оюуны спортын ордон /Увс, Улаангом сум/	БСШУСС	2016	2016	4700	4700	1			
11	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	БСШУСС	2010	2017	8229.3	9000	1			
	Нийт дүн				24,728.7	6,210.1	3	3	2	3

Хавсралт 3

УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР 2016 ОНД САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОВЧ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсвийн ерөнхийлөн захирагч	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжилт дутуу шалтгаан				
			Эхлэх	Дуусах			Гүйцэтгэчийн буруутай үйл ажиллагаанаас	Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас	Санхүүжилт дутуу олгогдсон	Гадна инженерийн дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй	ХАА-г хугацаа алдаж зохион байгуулсан
А		Б	1	2	3	4	5	6	7	8	9
1	Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах/Баян-Өлгий, Өлгий сум/ 4-р багц	ЭХС	2016	2016	995.0	995.0					1
2	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах/Төв/	ЭХС	2014	2016	3,940.0	3,940.0		1			
3	12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø 400 мм голчтой шугамын 2 Ø 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	ЭХС	2015	2016	7,296.0	7,296.0				1	
4	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	ЭХС	2014	2016	8,400.0	8,400.0	1				
5	Амгалан дулааны станц /348МВт/-ын туршилт, тохируулгын ажил /Улаанбаатар/	ЭХС	2015	2016	3,988.3	3,988.3		1			
6	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/	БХБС	2013	2016	5,000.0	750.0	1				
7	Цэвэр, бохир усны шугам сүлжээ, усан сан, насосны станц, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	БХБС	2013	2016	7,600.0	2397.7			1		
8	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур 2 ширхэг, биоцөөрөм барих /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	БХБС	2013	2016	8,519.1	1110.0			1		
9	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто зам /27 км/	ЗТХС	2013	2016	14,310.0	423.8	1				
10	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын барилга /50 км/	ЗТХС	2013	2016	6,789.6	757.8	1				
11	Аймгийн төвийн автозамын үлдэгдэл санхүүжилт 5.08 км /Орхон, Баян-Өндөр сум Дэнж баг/	ЗТХС	2013	2016	1,895.8	636.0			1		
12	Сумын төвийн гэрэлтүүлэг, авто зам, тохижилт /Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад, Манхан, Ховд, Мөст, Чандмань сумдад/	ЗТХС	2015	2016	2,470.0	653.4			1		
	Нийт дүн				71,203.8	31,348.0	4	2	4	1	1

Хавсралт 4

ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР 2016 ОНД САНХҮҮЖИЛТ ОЛГОГДООГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсвийн ерөнхийлөн захирагч	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан		
			Эхлэх	Дуусах			ХАА хүчингүй болсон	ХАА оройтсон	Бусад
А		Б	1	2	3	4	5	6	7
1	Хорооллын доторх зам, тохижилт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	ЗТХС	2016	2017	2,500.0	1,000.0	1		
2	Хужирт-Төвхөн Хийд-Улаанцутгалан чиглэлийн авто замын барилга /90,1 км/	ЗТХС	2013	2016	3,184.1	118.1			1
3	Замын Үүдийн хилийн боомтын 11 км замын 48000 м2 талбайн өргөтгөл	ЗТХС	2013	2017	2,113.0	952.4			1
4	Дарь Эх цогцолборын авто замын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21-р хороо/	ЗТХС	2016	2017	650.0	200.0		1	
	Нийт дүн				8,447.1	2,270.5	1	1	2

Хавсралт 5

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЛТ НЬ ЭХЭЛСЭН БОЛОВЧ 2016 ОНД ХӨРӨНГӨ ТӨЛӨВЛӨГДӨӨГҮЙ ОРХИГДСОН, БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ ЗӨРЧИГДСӨНТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭННИЙ СУДАЛГАА

(сая төгрөг)

№	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Захиалагч	Ажил гүйцэтгэх хугацаа		Төсөвт өртөг	Олгсон санхүүжилт /өссөн дүнгээр/	Ажлын гүйцэтгэл хувь	Шалтгаан
			Эхлэх	Дуусах				
1	Цэцэрлэгийн барилга, 100 ортой цэцэрлэг /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1-р баг Канад /	БСШУСС	2013	2014	4530	180.	66.	
2	75 хүүхдийн дотуур байр /Архангай, Хангай сум/	БСШУСС	2012	2013	5500	550.		
3	75 хүүхдийн дотуур байр /Архангай, Жаргалант сум/	БСШУСС	2012	2013	5500	550.		
4	Сургуулийн хичээлийн байр, спорт заалны барилга /Архангай, Төвшрүүлэх сум/	БСШУСС	2013	2015	2365.6	200.0		Сургуулийн барилга ашиглалтад орсон, спорт заалны барилгын заслын ажил хийгдээгүй.
5	Хүүхэд залуучуудын соёл үйлчилгээний цогцолбор, усан бассейн /Архангай/	БСШУСС	2013	2015	1470.0	1268.0		Барилгын гадна, дотор заслын ажил дутуу
6	Соёлын төвийн барилга /Орхон, Дэнж баг/	БСШУСС	2012	2017	1174.8	1067.1	80.	
7	Цэцэрлэгийн барилга, 75 ортой /Завхан, Цагаанхайрхан сум/	БСШУСС	2011	2015	6300	572.	66.	Ажлын гүйцэтгэл, зураг төсвөөс зөрүүтэй.
8	Соёлын төв, 400 суудалтай /Өвөрхангай, Уянга сум/	БСШУСС	2010	2015	1442.0	1274.2	86.	Гүйцэтгэгчийн чадавхи сул, дотор заслын ажил дутуу
9	Сургуулийн барилга, 120 суудалтай /Өвөрхангай, Ёсөнзүйл сум/	БСШУСС	2013	2015	7933	679.		
10	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр, 100 ортой эмнэлэг /Дорноговь, Замын-Үүд сум/	БХБС	2013	2016	4056.0	3423.0	76.	Барилгын норм ба дүрэм зөрчигдсөн тул барилга угсралтын ажил зогссон
11	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр, соёлын төв, спорт цогцолборын барилга 700 суудалтай /Дорноговь, Замын-Үүд сум/	БХБС	2013	2016	5844.1	2437.0	46.	Гүйцэтгэгч ажлын чадамжгүй.
12	Соёл, спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг сум/	БСШУСС	2013	2016	9714	844.	86.	Зарим ажил зураг, төсөлд тусгагдаагүй.
13	"Хархираагийн соёл" түүхийн төвийн барилга /Дорнод, Баян-Уул сум/	БСШУСС	2012	2015	2439	79.	76.	
14	Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн /Дорнод, Хэрлэн сум/	БСШУСС	2011	2016	1770.3	650.	50.	
15	Соёлын төв, спорт цогцолборын барилга, 700 суудалтай /Сүхбаатар, Баруун-Урт сум/	БСШУСС	2010	2012	1352.0	1200.0		Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
16	Соёлын төвийн барилга, 300 суудалтай /Өмнөговь, Ноён сум/	БСШУСС	2012	2015	8940	790.	50.	
17	Соёлын төвийн барилга, 200 суудалтай /Өмнөговь, Манлай сум/	БСШУСС	2014	2015	1200.0	1056.7	90.	
18	Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга, 850 суудалтай /Дундговь, Сайнцагаан сум/	БСШУСС	2011	2014	6900.0	2040.0		Арматур зэвэрсэн.

Үргэлжлэл - Хавсралт 5

19	Сургуулийн барилга, 640 суудалтай /Хэнтий, Биндэр сум/	БСШУСС	2014	2015	2631.0	126.4		
20	Сургуулийн өргөтгөлийн барилга, 240 суудалтай /Баянхонгор, Бууцагаан сум/	БСШУСС	2012	2015	936	500.		Шинэ сумын төслийн хүрээнд сургууль баригдаж ажил давхардсан.
21	Соёлын төвийн барилга, 250 суудалтай /Баянхонгор, Бууцагаан сум/	БСШУСС	2008	2015	664	252.		Шинэ сумын төслийн хүрээнд сургууль баригдаж ажил давхардсан.
22	Спорт цогцолбор, усан бассейны барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	БСШУСС	2014	2014	9902.1	899.		Олон жил зогсонги байдалтай байснаас барилгын хийц, чанар муудсан.
23	Эмнэлгийн барилга, 10 ортой /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон/	ЭМС	2013	2016	580	580.		
24	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ортой /Говь-Алтай, Цээл сум/	БСШУСС	2010	2017	1013.4	38.		
25	Геронтологийн төв, 60 ортой /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭМС	2011	2019	7392.9	222.0		Барилгын ажил зогсонги байдалтай.
26	Төрөх эмнэлэг, 300 ортой /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ЭМС	2010	2012	19000.0	000.0		Барилгын ажил зогсонги байдалтай.
27	Эмнэлгийн барилга, 10 ортой /Улаанбаатар, БЗД, Хонхор тосгон/	ЭМС	2012	2015	773	729.		Гараашийн барилга дугуу
28	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажил /Улаанбаатар, СХД 30 хороо, Хилчин хотхон/	БХБС	2013	2016	5000.0	400.0		Зураг төсөв магадлалаар баталгаажаагүй. Ажлын гүйцэтгэл чанаргүй, илүү санхүүжилт авсан, гэрээний үүргээ биелүүлээгүй тул үлдэх 500.0 сая төгрөгт ҮАГ-аас төлбөрийн акт тавьсан.
29	Спорт заалны барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 61 дүгээр сургууль/	БСШУСС	2012	2016	1050.0	519.		Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
30	Боршоо олон улсын худалдааны төв /Увс/	ХХААХУС	2011	2012	820	210.		Суурь болон 1 дүгээр давхрын өрлөг хийгдээд царцаагдсан.
31	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/	БСШУСС	2015	2015	766	300.	50.	
32	Байгаль орчны газрын конторын барилга /Хөвсгөл/	БОАЖС	2012	2016	1094.9	556.	66.	
33	Сургуулийн барилга, 220 суудалтай /Хөвсгөл, Цагаан-үүр сум/	БСШУСС	2014	2016	1591.1	131.7	56.	Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
34	Соёлын төв /Хөвсгөл, Рашаант сум/	БСШУСС	2014	2016	1450.0	864.	66.	Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
35	Үйлчилгээний төвийн барилга /Сэлэнгэ, Ерөө сум/	БХБС	2012	2016	250	250.	40.	Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
36	Төрөх эмнэлэг, 50 ортой /Дорноговь, Сайншанд сум/	ЭМС	2011	2015	1817.8	973.	46.	Барилга угсралтын ажлын явцад барилгын норм ба дүрэм зөрчигдсөн
37	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Гурван тэс сум/	БСШУСС	2012	2015	1123.1	179.6		
38	Мэргэжлийн хяналтын конторын барилга /Говь-Алтай, Есөнбулаг/	Шадар сайд	2012	2012	9761	30.		
39	Шонхор хүүхдийн зуслангийн соёлын төвийн барилга /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/	БХС	2013	2013	1610	129.		
40	Хөдөө аж ахуйн МСҮТ-ийн үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Орхон, Баян-Өндөр сум/	ХНХС	2013	2015	2162.0	185.		Гэрээ цуцлагдсан.

Үргэлжлэл - Хавсралт 5

41	Нутгийн удирдлагын ордон /Завхан, Их-уул сум/	ЗГХЭГ	2013	2015	9700	2200		
42	Шүүх, прокурорын нэгдсэн барилгын дуусгалт /Улаанбаатар, Хан-Уул	ШЕЗ	2013	2015	52000.0	7370.3		
43	Төв аймгийн Зуунмод сумын Баянхошуу багийн 1.5 км авто замын шинэчлэлийн дуусгалын ажил /Төв, Зуунмод сум/	ЗТХС	2013	2013	3170	67		
44	Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга /Улаанбаатар, Буянт-Ухаа/	ЗТХС	2011	2013	6759.5	6116.5		
45	Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын дэд өртөө, гадна цахилгаан, гадна холбооны ажил /Улаанбаатар, Буянт-Ухаа/	ЗТХС	2012	2013	1005.5	552		
46	Засаг даргын Тамгын газрын байр /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	ЗГХЭГ	2011	2012	3500	3200	1000	Гүйцэтгэгч компаний бичиг баримтын асуудлаас шалтгаалан одоог хүртэл ашиглалтад өгөөгүй.
47	Гэр хорооллын бохир усны 2.4 км шугам /Сэлэнгэ, Сайхан сум/	БХБС	2012	2014	2600	2380		Инженер геологийн дүгнэлт буруу гарснаас ашиглалтад хүлээлгэн өгөөгүй.
48	Сумын төвийн шинэчлэл /Дорнод, Баян-Уул сум/	БХБС	2014	2015	5000.0	4000.0	700	Магадлал хийгдэж баталгаажуугүй зураг, төслөөр чанаргүй хийгдсэн
Нийт дүн					160,499.7	64040.1		

Хавсралт 6

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ ДУУССАН БОЛОВЧ АШИГЛАЛТГҮЙ, ХЭРЭГЖИЛТ ДУТУУ ТАХ-НИЙ СУДАЛГАА

(тэрбум төгрөг)

№	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгч	Төсөвт өртөг	Хэрэгжсэн хугацаа		Ашиглалтгүй байгаа шалтгаан
				Эхлэх	Дуусах	
Ажил бүрэн хийгдсэн боловч хэлхээний иж бүрдэл хангагдаагүйгээс ашиглалтгүй, улсын комисс хүлээн аваагүй						
1	Шинэ Яармаг" хорооллын цахилгааны 110/35/10 кВ-ын дэд станцын барилга угсралт	Цагаан хорол ХХК	19	2014	2016	Их тойруу 110 кВ-ын ЦДАШ-ын Сонгино, Зайсангийн хэсэг ашиглалтанд ороогүй учраас хүчдэлд залгах боломжгүй
2	Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 2 Ø 700 мм-ийн голчтой 4 км шугамын барилга угсралт	Хасу мегаватт ХХК	6	2014	2016	Зарцуулалтын горим ажиллагаанд бүрэн залгагдаагүй, хүрэлцээтэй хэрэглэгч байхгүй
3	Гандирс хорооллоос Бортолгой хүртэл дулааны гол шугамын өргөх насао станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	Тэргүүн инвест ХХК	6.8	2013	2014	Баянголын аманд баригдах 18000 айлын орон сууц баригдаагүй учир улсын комисс ажиллаагүй
4	Баянголын амны Гандирс хорооллоос Бортолгой хүртэл дулааны гол шугамын өргөх насос станцын зураг төсөл, барилга угсралтын ажил	Мон Инж Бар ХХК	3	2013	2014	Баянголын аманд баригдах 18000 айлын орон сууц баригдаагүй учир улсын комисс ажиллаагүй
5	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт удирлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 шилэн кабель бүхий аянгын тростой ЦДАШ-ын зураг төсөл, барилга угсралтын ажил	Смарт-крафт ХХК	8	2014	2015	Улаанбаатар хотын Сонгино 220/110/35 кВ-ын дэд станц, Их тойруу 110 кВ-ын ЦДАШ-ын Сонгино, Зайсангийн хэсэг дуусаагүйгээс ашиглах боломжгүй
6	Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл, 2 дугаар үе шатны ажил /Улаанбаатар/	Бумбод ХХК	14.3	2015	2016	Улаанбаатар банкны эзэмшлийн газраар байгууламжийн трасс дайрч гарснаас ажил зогссон
7	Сонгино хайрхан дүүргийн 5,6-р хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 ф300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ш ус дулаан дамжуулах төв, ф150 мм-ийн голчтой 137 метр ...шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Есөн талст-Оргил констракшн ХХК	9	2014	2016	Газар чөлөөлөгдөөгүй
8	Берлин эко орон сууцны хорооллын дунд баригдах "Буянт-Ухаа" 2х40 МВА 110/10 кВ-ын дэд станц, 2.5 км урт 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	Ньюпрогесс ХХК	13	2014	2016	Газрын маргаантай
9	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах	Аркади ХХК	9	2014	2016	Төв аймагт баригдаж байгаа 1000 айлын орон сууцны барилгын талбайн өндөржилт, авто болон явган хүний зам, С блокны барилга баригдаагүйгээс ажил удааширсан
10	12 а магистральный ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ø 400 мм голчтой шугамын 2 Ø 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	Альянстех ХХК	7.3	2015	2016	Дүнжингарав хорооллын оршин суугчдын эсэргүүцлийн улмаас НЗАА-аас ирүүлсэн 2016 оны 01/1503 тоот шийдвэрээр ажил зогссон
	Нийт дүн		89			

Хавсралт 7

ШИЛЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2016 ОНД ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

№	ТЭЗ	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хуулиарх төсөвт өртөг		Зөрүү	Нэмэгдсэн шалтгаан
				2016 онд	2015 онд		
А			1	2	3	3=2-3	5
1	ШС	III.1.1.2	Аврах гал унтраах ангийн барилга /Төв, Зуунмод/	2,700.0	1,600.0	1,100.0	ЗТБХС-ын 181 дүгээр тушаалаар батлагдсан барилгын үнэ бүрдэлийн журмаар дахин тооцоолсон төсөвт өртөг нэмэгдсэн
2	ЗГХЭГ	IY.1.2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Булган сум/	4,137.5	2,984.5	1,153.0	Хэрэгжих хугацаа удааширснаас төсөвт өртөг нэмэгдсэн
3	ХНХС	YIII.3.1.6	Хараагүй иргэдийн 90 айлын орон сууцын барилга /Улаанбаатар/	4,850.0	4,000.0	850.0	2015.05.14-ны өдрийн 456/2015 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртөг 4,849.5 сая төгрөгөөр баталгаажсан
4	БСШУСС	XI.1.1.92	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Булган, Булган сум, 1 дүгээр цэцэрлэг/	1,340.2	1,040.0	300.2	
5	БСШУСС	XI.1.1.24	Сургуулийн барилга, 928 суудал /Хэнтий, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/	5,089.9	4,429.0	660.9	Төсөвт өртгийг нэмэгдүүлж баталгаажуулсан баримт байхгүй.
6	БСШУСС	XI.1.1.30	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар сургууль/	7,026.5	6,759.3	267.2	Гадна инженерийн шугам сүлжээний төсөвт өртгийн нэмж тусгасан
7	БСШУСС	XI.1.1.35	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/	5,654.3	4,693.5	960.8	Төсөвт өртгийг БХТ-ийн 2015.11.25-ны өдрийн 1220/2015 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 5,274.1 сая төгрөгөөс тодорхой шалтгаангүйгээр 380.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.
8	БСШУСС	XI.1.1.82	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Завхан, Улиастай сум, Дэвшил сургууль/	2,491.5	1,780.0	711.5	2014.09.03-ны өдрийн 1192/2014 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр төсөвт өртгийг 2,491.5 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан.
9	БСШУСС	XI.1.1.53	Сургуулийн барилга, 320 суудал /Дундговь, Гурвансайхан сум/	2,898.5	2,605.5	293.0	2015.10.23-ны өдрийн 1108/2015 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр 272.7 сая төгрөгөөр хянаж баталгаажуулсан боловч 2016 онд 20.3 сая төгрөгөөр илүү тусгагдсан
10	БСШУСС	XI.2.1.18	Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилга, 1080 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	19,604.7	18,354.7	1,250.0	Нэмэлт ажлын 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгт 2016.12.26-нд магадлал хийгдэж өртөг нэмэгдсэн
11	БСШУСС	XI.2.1.19	Соёлын төвийн барилга /Төв, Баянцагаан сум/	1,500.0	1,000.0	500.0	Гадна инженерийн шугам сүлжээний ажлын төсвийг БХТ-ийн 0731/2016 дугаар магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан
12	БСШУСС	XI.4.1.6	Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/	7,400.0	2,800.0	4,600.0	2013 онд батлагдсан зураг, төсөлгүйгээр хуулиар батлагдсан. Уурын зуухны барилга, цахилгааны дэд өртөө анхны төсөвт тусгаагүйгээс төсөвт өртөг нэмэгдэж 7,477.0 сая төгрөгөөр баталгаажсан. Гэрээний дүн 7,210.0 сая төгрөг
13	ЗТХС	XII.1.1.9	Сумын доторх хатуу хучилттай авто зам, 3 км /Завхан, Тосонцэнгэл сум/	1,957.7	1,782.0	175.7	2016 оны төсөвт 1,957.7 сая төгрөгөөр батлагдсан хэдий ч 2017 онд төсөвт өртөг залруулга хийгдэн 1,782.0 сая төгрөгөөр нэмэгдэж баталгаажсан
ДҮН				66,650.8	53,828.5	12,822.3	

2017 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/114/

Улаанбаатар-2017

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар, "Засгийн газраас олгосон векселийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг гуравдугаар, тус аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Ж.Эрдэнэбат/-д зөвлөсүгэй.


5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны
6 дугаар сарын 9-ний өдрийн А/... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

УХА0122

/сая төгрөг/

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөр, зөрчлийн товч утга	Дугаар	Төлбөрийн актын дүн	Албан шаардлагын дүн
	Байгууллага	Албан тушаал				
Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ҮАГ-ГАГ/2017/02-ГА/						
1	ЗТХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх	01/89- ҮАГ-ГАГ/2017/02-ГА		2,462.4
2	ЭХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Техник хяналтын зардлын тооцоог нийлэлгүй гүйцэтгэгчид олгосон	01/19- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	14.2	
3	ГХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Хийгдээгүй ажлын санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй барьцаа хөрөнгийн дансанд байршуулсныг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	01/20- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	300.0	
4	ХНХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Хийгдээгүй ажлын санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй Төрийн банкинд байршуулсныг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	01/21- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	262.6	
5	ХНХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Урьдчилгаа төлбөрийг гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон	01/22- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	821.0	
6	ХНХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Техник хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх	01/23- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	27.3	
7	ХНХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Улсын төсөвт төвлөрүүлэх тухай	01/24- ҮАГ-ГАГ/2017/02-ГА	889.1	
8	ЭМЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Экспертиз, магадлалаар баталгаажаагүй төсвийг хянуулах.	01/90- ҮАГ-ГАГ/2017/02-ГА		1,518.6
9	ЭМЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Бодит бус гүйцэтгэлээр гүйцэтгэгч байгууллагад санхүүжилт олгосон албан тушаалтанд хариуцлага тооцох	01/91- ҮАГ-ГАГ/2017/02-ГА		436.2

10	ЭМЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Гэрээний үнийн дүнгээс давуулж санхүүжилт олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	01/25- YAГ-ГAГ/2017/02-ГA	1.6	
11	ЭМЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Техник хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагад олгосон тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	01/26- YAГ-ГAГ/2017/02-ГA	3.9	
12	ЭМЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Техник хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	01/27- YAГ-ГAГ/2017/02-ГA	12.4	
13	БХЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Бодит бус гүйцэтгэлээр гүйцэтгэгч байгууллагад санхүүжилт олгосон зөрчлийг арилгуулах	01/92- YAГ-ГAГ/2017/02-ГA		132.0
14	БСШУСЯ	Төрийн нарийн бичгийн дарга	Төсөл, арга хэмжээний барилга угсралтын гүйцэтгэл, санхүүжилт хянан үзэж, гэрээний хэрэгжилтийг хангуулах	01/93- YAГ-ГAГ/2017/02-ГA		217.0
ДҮН					2,332.1	4,766.2